

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-23
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	24-67

<i>1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2022.12.30-ны өдөр, Засгийн газар 2023.01.18-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	24-28
<i>2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	26-46
<i>3.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	46
<i>4.Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний комиссын 2024 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх</i>	46-66
<i>5.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i>	66-67

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 27-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 00 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.
Томилоттой: Ш.Адъяа, Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Б.Дэлгэрсайхан, Х.Нямбаатар, Б.Пүрэвдорж, Н.Учрал, Б.Энх-Амгалан;
Чөлөөтэй: Ц.Сэргэлэн.

Нэг.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа 2022.12.30-ны өдөр, Засгийн газар 2023.01.18-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч М.Цолмон, Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн газрын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт Б.Гантуяа, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Төрмөнх нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг,

Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т “нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан дахин санал хураалгах шаардлагатай гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан, 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 20¹.1 дэх хэсгийн “Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, “хөтөлбөр” гэсний дараах “эсхүл” гэснийг хасаж, 20¹.3, 29.6 дахь хэсгийн “20¹ дүгээр зүйлд” гэснийг “20¹.1, 20¹.2-т” гэж өөрчилж, мөн 29.6 дахь хэсгийн “төр,” гэснийг хасаж, “төслийн 2 дугаар зүйлийн мөн хэсгийн “дарга,” гэсний өмнө “байгууллагын” гэж “тэдгээрийн” гэсний дараа “тэргүүн дэд дарга, дэд дарга” гэж, “орлогч” гэсний дараа “дарга” гэж нэмэх гэснийг “мөн хэсгийн “аймаг, нийслэлийн Засаг дарга” гэсний өмнө “тэдгээрийн тэргүүн дэд дарга, дэд дарга, орлогч дарга,” гэж,” өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. *“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч М.Цолмон, Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн газрын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт Б.Гантуяа, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, мөн газрын Судалгаа шинжилгээний албаны дарга, эрхэлсэн комиссар Ц.Шинэбаяр, Мөрдөн

шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга, ахлах комиссар Ч.Жаргалбаатар, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар Л.Хангарьд, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Х.Оюунцэцэг, “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ш.Батцэнгэл, Ц.Отгонбаатар, С.Төрмөнх нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Тогтоолын төсөлтэй холбоотой санал

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн “43 дугаар зүйлийн 43.1” гэснийг “5 дугаар зүйлийн 5.1” гэж өөрчлөн, 1 дэх заалтын “1 дүгээр хавсралтаар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2 дугаар” болон “тус тус” гэснийг хасаж, тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасаням хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж дугаарыг 3 болгон өөрчлөх:

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг

төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Тогтоолын төслийн хавсралттай холбоотой санал

Б.Энхбаяр: 1.Тогтоолын төслийн хавсралтын гарчгийн дараа доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, төслийн заалт бүрийн өмнөх “Үйл ажиллагаа” гэснийг хасах:

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдсан, 2023-2030 онд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.1 дэх хэсгийн 1.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.4.Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор тогтоосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглож, хэрэгжилтийг хангана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Ажлын хэсэг уг саналаа татан авсан талаар Байнгын хорооны дарга Б.Энхбаяр мэдэгдэж, санал хураалт явуулаагүй болно.

3.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.2 дахь заалтын “Улс төрийн” гэсний өмнө “Төрийн” гэж нэмж, “албан тушаалтныг” гэсний дараах “өөрийн”

гэснийг “хувийн” гэж, зорилт 1.4 дэх хэсгийн 1.4.1 дэх заалтын “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.5 дахь хэсгийн 1.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.5.2.Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн явуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.6 дахь заалтын “сайжруулах” гэсний дараа “, хариуцлагыг нэмэгдүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 5.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.6 дахь заалтын “сайжруулах” гэсний дараа “, хариуцлагыг нэмэгдүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.2 дахь заалтын “хөгжүүлнэ” гэснийг “хөгжүүлж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 2.1.5 дахь заалтын “төрийн албанд ёс зүйг төлөвшүүлнэ” гэснийг “чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлнэ” гэж, 2.1.7 дахь заалтын “төлүүлж, хяналт тавина” гэснийг “төлүүлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ” гэж, “2.1.8” дахь заалтыг “2.4.2” болгон дугаарлалтыг өөрчилж, 2.1.3 дахь заалтын “гол” гэснийг, 2.1.7 дахь заалтын “бий болгож,” гэсний дараах “төрд учруулсан” гэснийг болон 2.1.4 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.2 дахь хэсгийн “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж, 2.2.2 дахь заалтын “орчныг бүрдүүлнэ” гэснийг “зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж, 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалтын “зохих хэмжээний зарлагаа” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээний зарлагыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 7.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.2 дахь хэсгийн “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж, 2.2.2 дахь заалтын “орчныг бүрдүүлнэ” гэснийг “зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж, 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалтын “зохих хэмжээний зарлагаа” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун

тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээний зарлагыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.4.3 дахь заалт нэмж, мөн хэсгийн “хууль,” гэснийг хасах.

“2.4.3.Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан албан тушаалтнуудаас бусад хуулиар тогтоосон албан тушаалын халдашгүй байдлын хүрээг хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.5 дахь хэсгийн 2.5.3 дахь заалтын “бүрэн цахимжуулна” гэсний өмнө “үе шаттайгаар” гэж нэмж, мөн хэсгийн “Төрд байгаа” гэснийг “Төрийн үйл ажиллагааны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 3.3 дахь хэсгийн 3.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.3.Ашгийн бус салбар дахь терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Техник хэрэгжилтийн зөвлөмжид нийцүүлэн ашгийн бус байгууллагыг хамруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.6 дахь хэсгийн 5.6.2 дахь заалтын “хараат бус,” гэсний өмнө “улс төрөөс” гэж, 6.1 дэх хэсгийн 6.1.4 дэх заалтын “Хураасан,” гэсний өмнө “Хөрөнгө буцаасан,” гэж тус тус нэмж, зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтын “хориглоно” гэснийг “хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж, зорилт 5.2 дахь

хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “өгөх,” гэсний дараах “мөнгө угаах,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.6 дахь заалтын “тооцно” гэснийг “тооцдог болох эрх зүйн орчныг бий болгоно” гэж өөрчилж, 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.8.Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгийг хураах нэмэгдэл ялын төрөл бий болгох асуудлыг судалж, санал боловсруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.11.Хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 14.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.11.Хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 14.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.11.Хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.15.Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмж, үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 шалгуурыг хангаж, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.2 дахь хэсгийн 6.2.4 дэх заалтын “шийдвэрлүүлнэ” гэснийг “шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бататгана” гэж, 6.3.1 дэх хэсгийн “болгоно” гэснийг “болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж өөрчлөн, 6.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.2.5.Эдийн засаг, авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг болон мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг суурь гэмт хэрэгт хамааруулах, гэмт хэргийн шинж, зохицуулалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, олон улсын стандартад нийцүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “суллахгүй байх” гэсний өмнө “шүүхээс” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 19.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “суллахгүй байх” гэсний өмнө “шүүхээс” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.12 дахь заалтын “механизмыг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчлөн, 6.4.11 дэх заалтын “нэгжийг” гэсний дараах “тодорхой тооны мөрдөгчтэйгөөр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.2.Тухайн жилийн Төсвийн тухай хуулийг эрх бүхий байгууллагаас боловсруулж өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлахдаа төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төвлөрүүлэх орлого, зарцуулах зардлыг нийт дүнгээр нь, түүнчлэн эдийн засгийн ангилал, төрөл, зориулалт тус бүрээр тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.8 дахь заалтын “жендерийн мэдрэмжтэй,” гэсний өмнө “хүний эрх,” гэж нэмж, 7.1.5 дахь заалтын “суурилж батлан” гэснийг “суурилсан эсэхийг хянах тогтолцоог бүрдүүлж,” гэж өөрчлөн, 7.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.11.Төсвийн захирагчийн албан тушаалд нэр дэвшигчдийг бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөөр өрсөлдүүлэх зарчмыг баримтлан сонгон шалгаруулж, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулж хэвшинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.13 дахь заалтын “төрийн аудитын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “гаргана” гэснийг “гаргадаг үйл ажиллагааг тогтмол болгоно” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.3 дахь хэсгийн “тусламж, тусгай сангийн” гэснийг “тусгай сан, гадаадын зээл, тусламжийн” гэж, 7.3.5, 7.3.6 дахь заалтыг 7.3.2, 7.3.3 болгон дугаарлалтыг өөрчилж, 7.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.4.Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 8.1.6 дахь заалт нэмэх:

“8.1.6.Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлага, төрийн оролцоог үе шаттай бууруулж, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: 25.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 8.1.6 дахь заалт нэмэх:

“8.1.6.Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлага, төрийн оролцоог үе шаттай бууруулж, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 9.4 дэх хэсгийн 9.4.2 дахь заалтын “болгож, контентыг шүүлтүүртэй” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 9.5 дахь хэсгийн 9.5.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.5.1.Төрийн албан хаагч, удирдах албан тушаалтнуудад авлигын эсрэг сургалтыг үе шаттай зохион байгуулах, ёс зүй, манлайллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай Зорилго 11 нэмэх:

“Зорилго 11.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог сайжруулна.

Зорилт 11.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.

11.1.1.Монгол Улсын Засгийн газар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, санхүүжүүлнэ. Яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Засгийн газар хариуцан ажиллана.

11.1.2.Авлигатай тэмцэх газрын бүтцэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг

үнэлэх, зөвлөмж өгөх, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх чиг үүрэг бүхий Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Ажлын алба ажиллана.

11.1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт хариуцсан байгууллагууд хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлнэ.

11.1.4.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар нь Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн, санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

11.1.5.Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тайлан, үнэлгээ, санал, дүгнэлтийг хэлэлцэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ

Б.Энхбаяр: 1.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “төлбөргүй” гэсний өмнө “үнэ” гэж, 9.2 дахь хэсгийн 9.2.1 дэх заалтын “төлөвшүүлнэ” гэсний өмнө “олон нийтэд” гэж, 9.4 дэх хэсгийн 9.4.4 дэх заалтын “Боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.5 дахь хэсгийн 1.5.3 дахь заалтын “зохицуулалт, механизмыг” гэснийг “зохицуулалтыг” гэж, 2.1.2 дахь заалтын 3.1.3 дахь заалтын “тавих” гэснийг “тавигдах” гэж, 3.2.4 дэх заалтын “иргэдийн шууд хяналт, мониторинг хэрэгжүүлэх” гэснийг “иргэд шууд хяналт тавих боломжийг” гэж, 3.3.2 дахь заалтын “дэмжлэг” гэснийг “тусламж” гэж, 5.1.4 дэх заалтын “авлигын гэмт хэрэг, зөрчлийн болон” гэснийг “авлигын болон зөрчлийн гэмт хэргийн” гэж, 5.1.6 дахь заалтын “батлагдсан төсвийн хэмжээнээс” гэснийг “батлагдсан төсвөөс” гэж, 5.4.4 дэх заалтын “хүний нөөцийн чадавхыг бий болгоно” гэснийг “хүний нөөцийг бэхжүүлнэ” гэж, 6.2.3 дахь заалтын “яллах ажиллагаан дахь” гэснийг “яллах ажиллагааны явцад” гэж, “эзэмшүүлнэ” гэснийг “эзэмших нөхцөл боломжийг бий болгоно” гэж, 6.2.4 дэх заалтын “гадаад оронд” гэснийг “гадаад улсад” гэж, 6.4.5 дахь заалтын “ил тод байдлыг бий болгох” гэснийг “ил тод байдлыг бий болгоно” гэж, 6.4.9 дэх заалтын “санхүүгийн мэдээлэл,” гэснийг “санхүү, орлогын эх үүсвэрийн” гэж, зорилт 7.1 дэх хэсгийн “Төсвийн төлөвлөлтийг” гэснийг “Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог” гэж, “оролцоог хангаж, тогтолцоог” гэснийг “оролцоог хангах замаар” гэж, 7.2.2 дахь заалтын “зохион байгуулж”

гэснийг “зохион байгуулдаг тогтолцоог бүрдүүлж,” гэж, 7.2.3 дахь заалтын “данснаас хассан” гэснийг “данснаас хасагдсан” гэж, 7.4.3 дахь заалтын “цахим хэлбэрт бүрэн шилжүүлнэ” гэснийг “бүрэн цахимжуулна” гэж, 8.4.2 дахь заалтын “нээлттэй сонголт” гэснийг “нийтийн сонголт” гэж, 9.3.1 дэх заалтын “Бүх шатны сургалтын” гэснийг “Бүх түвшний сургалтын” гэж, 9.4.3 дахь заалтын “зүйлсийг бууруулах дүн шинжилгээ хийнэ” гэснийг “зүйлсэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “эдгээрийг амлах” гэсний өмнөх “эсхүл” гэснийг, 2.4 дэх хэсгийн “хууль,” гэснийг, 5.4.4 дэх заалтын “шаардлагатай” гэснийг, 6.2.3 дахь заалтын “олон улсын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 3.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “эдгээрийг амлах” гэсний өмнөх “эсхүл” гэснийг, 2.4 дэх хэсгийн “хууль,” гэснийг, 5.4.4 дэх заалтын “шаардлагатай” гэснийг, 6.2.3 дахь заалтын “олон улсын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: 3.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “эдгээрийг амлах” гэсний өмнөх “эсхүл” гэснийг, 2.4 дэх хэсгийн “хууль,” гэснийг, 5.4.4 дэх заалтын “шаардлагатай” гэснийг, 6.2.3 дахь заалтын “олон улсын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Найруулгын саналын 2 дахь санал хураалтын 5.1.4 дэх заалтын “авлигын гэмт хэрэг, зөрчлийн болон” гэснийг “авлигын болон зөрчлийн гэмт хэргийн” гэж найруулах гэсэн санал хураалтыг хүчингүйд тооцох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Д.Цогтбаатар нарын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.1 дэх хэсгийн үйл ажиллагааны 1.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын “Зорилго 8” гэснийг “Зорилго 3” болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч М.Цолмон, Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн газрын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт Б.Гантуяа, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, мөн газрын Судалгаа шинжилгээний албаны дарга, эрхэлсэн комиссар Ц.Шинэбаяр, Мөрдөн шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга, ахлах комиссар Ч.Жаргалбаатар, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, Судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар Л.Хангарьд, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Х.Оюунцэцэг, “Нээлттэй нийгэм форум” ТББ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн Үндэсний комиссын 2024 оны төсвийн төслийн талаар хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн Төсвийн асуудал хариуцсан ахлах референт А.Эрдэнэцэцэг, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Наранбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн комиссын тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, ахлах нягтлан бодогч Б.Бадамсэрээжид нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан П.Хулан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ш.Батцэнгэл, Ц.Отгонбаатар, Д.Гэрэлт-Од, Ч.Сарантуяа, С.Төрмөнх, Б.Одмандах нар байлцав.

1.Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны төсвийн төслийн талаар:

Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, 1.Улсын дээд шүүхийн шүүгчийн туслахуудын орон тоо нэмэхийг хасах, үр дүнгийн урамшууллыг жилд 80 хувиар олгодог байх, бараа үйлчилгээний бусад зардал дээр албан хаагчдыг гадаад хэл, Монгол бичгийн сургалтад хамруулах 207.8 сая, мэргэшүүлэх сургалт дээр 72 сая төгрөг, нийт 280 сая төгрөгийг нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Энхбаяр, Ш.Раднаасэд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн төслийн талаар:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар хуралдааныг 13 цаг 21 минутаас 13 цаг 24 минутад даргалав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ш.Раднаасэд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилгыг 12 тэрбум 801 сая төгрөг бүтнээр нь суулгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 9
Бүгд: 10
10.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Багануур дүүргийн шүүхийн барилга төсөвт өртөг 6.3 тэрбум төгрөг, 2024 онд санхүүжих нь 2 тэрбум гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Шүүхийн сахилгын хорооны 2024 оны төсвийн төслийн талаар:

Шүүхийн сахилгын хорооны 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: Шүүхийн сахилгын хорооны 2024 оны төсвийн төслийг төсвийн хязгаарт нийцүүлж хасах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 10
Бүгд: 10
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан Багануур дүүргийн шүүхийн барилгыг санхүүжүүлэх санал Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн багцад багтаж байгааг талаар Сангийн яаманд хүргүүлэх тухай мэдэгдэв.

Хүний эрхийн Үндэсний комиссын 2024 оны төсвийн төслийн талаар:

Хүний эрхийн Үндэсний комиссын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан хариулж, тайлбар хийв.

Б.Энхбаяр: 1.Хүний эрхийн Үндэсний Комиссын барилга 8 тэрбум гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 9
Бүгд: 10
10.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Хүний эрхийн Үндэсний Комиссын орон тоог 2023 онд 82 байсныг 93 болгож нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 8
Бүгд: 10
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.82 ажилтны хоолны үнийн хөнгөлөлтөд 104.3 сая төгрөг нэмэх, Нийгмийн даатгалын шимтгэлд 13 сая төгрөг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Нийгмийн даатгалын шимтгэлд 27.8 сая төгрөг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 9
Бүгд: 10
10.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Шатахуун дээр 57.5 сая төгрөг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Мэдээлэл, сурталчилгааны материал, эвхмэл хуудас, ном хэвлүүлэхэд 2024 онд 50.8 сая төгрөг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 8
Бүгд: 10
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Гадаад албан томилолтыг өнгөрсөн оны төсвөөр батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 9
Бүгд: 10
10.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Дотоод албан томилолтын зардлыг 2023 оны түвшингөөр батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 9
Бүгд: 10
10.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Судалгааны ажилд нийт 440 сая төгрөгөөр 11 судалгаа хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10. Орчуулгын зардлыг өнгөрсөн оны түвшингөөр нь батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 8
Бүгд: 10
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11. Хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр 21 аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлэх нөлөөллийн ажилд 31.5 сая төгрөг батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12. Мэдээлэл сурталчилгааны зардалд 308.5 сая төгрөгийг тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13. Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 126 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14. 21 аймгийн ажилтанд сар бүр 20 хувийн цалинтай тэнцэх дэмжлэг үзүүлэх 93 сая төгрөгийг батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15. Албан хаагчдад нэг удаагийн тусламж, дэмжлэг олгоход 56.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 7
Бүгд: 10
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 14 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: “Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 35 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
11 цаг 00 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан гишүүдийн олонх ирсэн тул нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг танилцуулъя. Энхбаяр гишүүн ирсэн байна, Адьяаа гишүүн гадаад томилолттой, Алтанхуяг гишүүн ирсэн байна, Бат-Амгалан гишүүн гадаад томилолттой, Бямбацогт гишүүн гадаад томилолттой, Ганбат гишүүн ирсэн байна, Дэлгэрсайхан гишүүн гадаад томилолттой, Мөнхбаатар гишүүн ирсэн байна, Мөнх-Оргил гишүүн ирсэн байна, Мөнхцэцэг гишүүн ирсэн байна, Нямбаатар гишүүн гадаад томилолттой, Пүрэвдорж гишүүн гадаад томилолттой, Раднаасэд гишүүн ирсэн байна, Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Сүхбаатар гишүүн ирсэн байна, Сэргэлэн гишүүн чөлөөтэй, Учрал гишүүн гадаад томилолттой, Цогтбаатар гишүүн ирсэн байна, Энх-Амгалан гишүүн гадаад томилолттой.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газраас 2023 оны 6 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн эхний хэлэлцүүлгийг хийнэ.

3.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

4-т. Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Хүний эрхийн комиссын 2024 оны төсвийн төслийн талаар хэлэлцэнэ.

5.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар танилцуулна.

Ж.Сүхбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Адьяаагаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах

ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг нэгтгэсэн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төслийн холбогдох зүйл, хэсэгт нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, хэл найруулга, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслүүдийг та бүхэнд тараасан болно.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нийтийн албанд болон нийтийн болон хувийн хувийн хэвшлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн нэр томъёотой нэгтгэсэн хуулийн төслийг нийцүүлэх үүднээс анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн найруулгын саналыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүйн саналаар дахин санал хураалгах санал гаргаж байна.

1.Төслийн нэг дүгээр зүйлийн хорийн нэг итрих нэг дэх хэсгийн Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн гэснийг Засаг дарга гэж өөрчилж, хөтөлбөр гэсний дараах эсхүл гэснийг хасаж, хорийн нэг итрих гурав, хорин есийн зургаа дахь хэсгийн хорийн нэг итрих нэг дүгээр зүйлд гэснийг хорийн нэг итрих нэг, хорийн нэг итрих хоёрт гэж өөрчилж, мөн хорин есийн зургаа дахь хэсгийн төр, гэснийг хасаж, төслийн хоёр дугаар зүйлийн мөн хэсгийн дарга, гэсний өмнө байгууллагын гэж, тэдгээрийн гэсний дараа тэргүүн дэд дарга, дэд дарга гэж, орлогч гэсний дараа дарга гэж нэмэх гэснийг мөн

хэсгийн аймаг, нийслэлийн Засаг дарга гэсний өмнө тэдгээрийн тэргүүн дэд дарга, дэд дарга, орлогч дарга, гэж нэмэх гэж өөрчлөх. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.
Манай хэд нэг ийм.

Б.Энхбаяр: Байнгын хороонд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Б.Гантуяа Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн газрын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээр тэмцэх асуудал хариуцсан ахлах референт, Баярсайхан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт дүн шинжилгээний албаны дарга, Ш.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, М.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Байнгын хороонд хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэнтэй холбоотойгоор асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Байнгын хорооны гишүүдийнхээ амар, амгаланг айлтгая. Энэ Авлигатай тэмцэх өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудал бол чухал асуудал гэж ойлгож байна. Энэ хуулийг бол батлах хэрэгтэй. Батлахыг нь дэмжиж байна. Хэд хэдэн хоёр, гурван асуулт байна надад.

Нэгдүгээрт энэ нийтийн ашиг сонирхол энэ асуудлаар хэдий хэмжээний

хүн Авлигатай тэмцэх газарт байцаагдаж байна вэ нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт энэ орон нутагт, аймагт тендер шалгаруулалт хэдэн хувь нь явагдаж байна. Тэгээд тэрэнтэй холбоотойгоор ямар ямар ашиг сонирхлын зөрчил гарч байна вэ. Энэ талаар судалгаа тооцоо байна уу. Ихэнх аймгийн Засаг дарга нар, дунд тушаалын төрийн албан хаагчид тендер шалгаруулдаг, тендерт оролцдог энэ улсууд маань бас ард олон нийттэй ингээд иргэдтэй уулзаад явж байхад маш их шүүмжлэлтэй байгаа. Маш их хэл амтай. Тэр тендер шалгаруулалтыг нь авдаг цөөхөн хэдэн компаниуд байдаг. Тэгээд барьж байгуулсан объектууд нь чанарын шаардлага хангахгүй, сургуулийн хүүхдийн дотуур байр энэ тэр гэхэд хамгийн чанар муутай, хамгийн муу материалаар хийсэн ийм зүйлүүд байна. Тэгээд өөрөө тэр аймгийн удирдлагууд нь гэхэд бол орон нутагт дандаа уурын зуухтай ч юм уу, төсвөөс санхүүждэг тийм юмыг хувьчлаад авчихсан, эзэмчихсэн.

Нөгөө талаар болохлоор тэр зам, гүүрний ашиглалтын компаниуд тэнд ингээд хувьтай ажиллуулдаг ийм улсууд байдаг. Энэ юмнууд энүүгээр ингээд зогсох уу, тэрийг зохицуулах уу, тэр хүмүүс бол ах дүү, төрөл саднаас гадна бас өөрсдийн хувь эзэмшдэг компаниараа дамжуулаад энэ нийтийн ашиг сонирхол энэ төрийн үйлчилгээний ажилд дангаараа оролцоод явдаг иймэрхүү зүйлүүд байна гэж ойлгож байгаа. Энэ талаар надад тодруулаад, хариулаад энэ хуультай холбогдох уу, уягдах уу гэдгийг бас тодруулж өгөөч гэж хүсэж байна.

Б.Энхбаяр: 2 номерын микрофон хариулъя. Нэр, албан тушаалаа танилцуулаад Ганбат гишүүний асуултад хариулъя.

Б.Баярсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн

бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Баярсайхан байна.

Нийтдээ 2022 оны байдлаар Авлигатай тэмцэх газарт 1520 эрүүгийн гэмт хэрэг, авлига албан тушаалын гэмт хэрэг шалгагдсан. Үүнээс төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэгт нийтдээ 1011 байгаа. Энэ хэрэгт холбогдсон албан тушаалтнуудын хувьд бол 1184 албан тушаалтан энэ дээр холбогдсон байгаа.

Манайхаас бас гэмт хэргээс гадна авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг шалгадаг байгаа. Энэ гомдол, мэдээллээс ингээд аваад үзэхээр багагүй хувь нь бол албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн ийм гомдол, мэдээллүүд байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ нийт энэ 2022 онд шалгасан 653 өргөдөл, гомдол, мэдээллийн 112 нь албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн, хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон ийм асуудлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ ашиг сонирхолтой холбоотой энэ асуудлуудыг зайлиггүй зохицуулах шаардлагатай гэж харж байна. Хариуллаа.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Уул нь би их маш тодорхой асуултауд асуусан. Болохгүй бол чуулган дээр энэ миний асуултад бэлдээд ирээрэй. Тэр юм хумаа үзэж хараад. Би давтаж асууна шүү. Энийг бүүр тэртээ тэргүй хүмүүс хараад бас сонсохыг хүсээд сууж байгаа. Нэг.

Хоёрдугаарт энэ өөрийнхөө ашиг сонирхол, хөрөнгө орлогынхоо мэдүүлэг ингээд өгч байгаа албан тушаалтнууд байгаа гэж ойлгож байна Авлигатай тэмцэх газар. Авлигатай тэмцэх газрын өөрийнхөн нь хөрөнгө орлогын мэдүүлгээ бас хаана, яаж өгөөд байгаа билээ, хэдий хэмжээний хүмүүс хамрагдаж байна.

Энэ олон тооны хөрөнгө орлогын мэдүүлгийг байнга хянаад байж чадаж байгаа юу, хэдийд. Тэгээд нөгөө талаар энэ хууль маань батлагдаад ердийн журмаараа үйлчлэх гээд байна уу, нөгөө төрийн мэдээлэлд гараад 10 хоносны дараа юу. Эсвэл тодорхой хугацаанаас эхэлж үйлчлэх юм уу.

Б.Энхбаяр: 2 номерын микрофон Сайнзориг дарга хариулъя.

П.Сайнзориг: Хурал даргалагч зөвшөөрвөл бас эхний асуулт дээр бас АТГ бас нэмээд тодруулж хариулъя гэнэ.

Ганбат гишүүний асуултад хариулъя. Хоёр дахь асуулт буюу энэ ердийн журмаар үйлчлээд явна. Өөрөөр хэлэх юм бол “Төрийн мэдээлэл” сэтгүүл дээр хэвлэгдээд энэ хууль маань хүчин төгөлдөр, 10 хоногийн дараагаас хүчин төгөлдөр болно. Тодорхой асуудлууд дээр дагаж мөрдөх журмын зохицуулалт байгаа. Ажил эрхлэхтэй холбоотой асуудлууд.

Ер нь зүгээр өмнө нь хууль тогтоомжид нийцүүлж байгуулагдсан гэрээ, хэлцлийн хувьд бол энэ хуулийн үйлчлэл бол хамаарахгүй. Ийм байдалтай буюу тухайн харилцааг үргэлжлээд гэрээнийхээ заасныхаа дагуу харилцан гүйцэтгэлээ хийгээд дуусгавар болгох ийм зохицуулалт дагаж мөрдөх шилжилтийн ийм зохицуулалт дээр орсон байна.

Эхний асуулт дээр Баярсайхан.

Б.Баярсайхан: Эхний асуултад хариулъя. Нийтдээ улсын хэмжээнд 50 орчим мянган албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаад явж байгаа. Авлигатай тэмцэх газраас бол 170 орчим албан.../минут дуусав./

Б.Энхбаяр: Ганбат гишүүний бас асуултад чуулган дээр, нэгдсэн чуулган бас маргааш энэ асуудлыг хэлэлцэнэ. Энэ дээр бас нэмж тодруулж хариулаарай.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. 1 санал байгаа. Ажлын хэсгийн ахлагч Сүхбаатар, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн, гэж заасны дагуу 2/3-оор дэмжигдэх учиртай санал хураалт байгаа гэдгийг гишүүддээ хэлье. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Түрүүн тэр нөгөө манайд бас байгууллагын гэсний нь дарга гээд тавьчихсан шүү дээ. Тэр дарга гэдэг нь бас олон юмтай давхардаад явчихсан юм шиг байна лээ. Тэгээд манай хэд тээ. Тэгээд бас жоохон, жижигхэн тийм алдаатай тодотгол юмнуудаа засаад 2/3-оор хийх найруулгын л юм байгаа юм. Өөр бол зарчмын тийм агуулга байхгүй.

Тэгэхээр төслийн нэг дүгээр зүйлийн хорийн нэг итрих нэг дэх хэсгийн Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн гэснийг Засаг дарга гэж өөрчлөх, хөтөлбөр гэсний дараах эсвэл гэснийг хасаж, хорийн нэг итрих гурав, хорин есийн зургаа дахь хэсгийн хорийн нэг итрих дүгээр зүйлд гэснийг хорийн нэг итрих нэг, хорийн нэг итрих нэг, хоёрт гэж өөрчилж, мөн хорин есийн зургаа дахь хэсгийн төр, гэснийг хасаж, төслийн хоёр дугаар зүйлийг мөн хэсгийн дарга, гэсний өмнө байгууллагын гэж тэдгээрийн гэсний дараа тэргүүн дэд дарга, дэд дарга гэж, орлогч гэсний дараа дарга гэж нэмэх гэснийг мөн хэсгийн аймаг, нийслэлийн Засаг дарга гэсний өмнө тэдгээрийн тэргүүн дэд дарга, дэд дарга, орлогч дарга гэж нэмэх гэж өөрчлөх гээд дарга гэдэгтэй нь холбоотойгоор ингээд тодотгоод явчихсан юмнууд байж байгаа. Энийг хураалгаж өгөх асуудал байгаа.

Б.Энхбаяр: Саяын Сүхбаатар гишүүний уншиж танилцуулсан зүйлийг эхлээд бол горимын саналаар санал хураана. Энэ бол 2/3 байгаа. Саяын найруулгын шинжтэй өөрчлөлтийг ер нь санал хураах нь зүйтэй гэдэг горимын саналаар эхлээд санал хураая. Санал хураалт.

80 хувийн саналаар санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэн учраас сая ажлын хэсгээс уншиж танилцуулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

11.16 цаг

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Анхны хэлэлцүүлэгт, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гантуяа Монголбанкны Удирдлага, төлөвлөлтийн газрын мөнгө угаах терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт, Баасанням Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Шинэбаяр Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга, эрхэлсэн комиссар, Жаргалбаатар Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга, ахлах комиссар, Баярсайхан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга, ахлах комиссар, Дуламсүрэн Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар, Ш.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Оюунцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн ахлах шинжээч, Хангарьд Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар, Төр-Од “Трансперенси Интернэшнл Монгол” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал, Бадамрагчаа “Нээлттэй нийгэм” төрийн бус байгууллагын Эрх зүйн хөтөлбөрийн менежер гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Улсын Их Хурлын чуулганаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэлэлцэх эсэхийг дэмжсэн. Хэлэлцэх эсэхийг дэмжсэнтэй холбоотойгоор ажлын дэд хэсгийн хүрээнд 5 дахь өдөр, энэ амралтын өдрүүдэд, мөн өчигдөр бас ажлын дэд хэсэг хуралдсан. Ингээд гишүүдэд тараасан байгаа нийтдээ 29 зарчмын зөрүүтэй саналаар санал хураахаар гишүүдэд тараасан. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хөтөлбөрийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг шийдэх үед Улсын Их Хурлын гишүүдээс хэлж байсан асуудлууд, хөндөж байсан асуудлуудыг тусгаж саналын томъёоллыг та бүхэнд тараасан байгаа гэдгийг танилцуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэнэ.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал хураалтыг явуулна. Энэ чинь асуулт байдаггүй юм уу дэгээр. Санал хураалтууд. Асуулт байвал тухайн тухайн санал хураалт дээрээ асуулт асуух дэгтэй юм байна. Ингээд санал хураалт, саналын томъёоллуудаар санал хураалт явуулъя.

Мөнх-Оргил гишүүнээс 1 санал. Тэгье. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Тогтоолын төсөлтэй холбоотой санал,

1.Тогтоолын төслийн “43 дугаар зүйлийн 43.1” гэснийг “5 дугаар зүйлийн 5.1” гэж өөрчлөн, 1 дэх заалтын “1 дүгээр хавсралтаар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2 дугаар” болон “тус тус” гэснийг хасаж, тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулахыг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэ-т даалгасгай.” гэсэн томъёолол байгаа.

Та бүхэнд тарааснаас тэр “Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэнэ” гэдгийг хасаж би сая уншсан байгаа. Яагаад гэхээр Засгийн газар өөрөө батлахдаа энэ Авлигатай тэмцэх газрын саналыг авах ёстой. Угаасаа авч таарна. Заавал энийг тогтоолд бичээд байх шаардлагагүй юм байна гэдэг ийм байдлаар саналын томъёоллыг уншсан

байгаа. Санал. Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Хөтөлбөр батлагдах юм байна. Төсөв, санхүүгийн асуудал хэдий хэмжээний төсөв, санхүүг энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт судалгааны ажилд зарцуулах вэ. Энэ нь орон нутгийн төрийн байгууллагуудад хэрхэн яаж, аль төсөвт нь хэрхэн яаж суух юм бэ, нийт төсөв нь хэд юм. Одоо ингээд 10 сарын 1-нээс хэрэгжээд эхлэхээр одоо улсын төсөв багцлагдаж байна, боогдож байна. Санал хүргэгдсэн юм байна уу, үгүй юү. Ирэх жилийн ингээд 1 сарын 1, 10 сарын 1-нээс хэрэгжээд эхлэх юм байна. Тэгэхээр шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг гэхээр жишээ нь энэ жил хэд вэ, ирэх жил хэд вэ гэсэн ингээж тодорхой гарсан юм байна уу. Шаардлагатай гэдгийн цаана.

Б.Энхбаяр: Баасанням дарга хариулъя. 3 номерын микрофон.

З.Баасанням: Гишүүний асуултад хариулъя. Энэ хөтөлбөр маань үндсэндээ 2030 он хүртэл хэрэгжихээр 8 жилийн хугацаагаар тусгагдаж байгаа. Урьдчилсан тооцоогоор үндсэндээ 35.6 тэрбум гэсэн тооцоог хийсэн байгаа.

Гэхдээ Засгийн газраар төлөвлөгөө батлагдахлаар энэ дээр жил жилийн хариуцах байгууллагуудын хэсэг дээрээ сая авсан саналынх нь дагуу төсөв нь суугдаад явах юм үндсэндээ.

Тэгэхлээр тухайн жилийнх нь төсөвт нь хариуцсан байгууллагуудынх нь төсөвт жил жилдээ суугдаад батлагдаад явна. Энэ жилийн төсвийн санал дээрээ тодорхой хэмжээний урьдчилгаа төсвийг, саналаа тусгаад өгчихсөн явж байгаа. Тэгэхлээр энэ нь тухайн яг төлөвлөгөөнийхөө Засгийн газраар батлагдах төлөвлөгөөний ар дээр, хэрэгжих төлөвлөгөө дээрээ хүрэх түвшинд тэрэнтэйгээ танилцуулаад зарцуулагдах төсвийнх нь тооцоо нь тэн

дээрээ цуг батлагдаад гараад ирэхлээр тэн дээрээ тухайн хэрэгжүүлэх байгууллагынхаа төсөвт нь тухайн тухайн жилдээ суугдаад хөтөлбөрийн хэрэгжилтээ хангаад явахаар ингээд зохицуулаад явж байгаа.

Б.Энхбаяр: Одоо сая би дахиж унших шаардлагагүй дээ. Сая уншихсан учраас. Эхний 1 дэх саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Гишүүдэд, хамгийн хамгийн сайн кофеноос Цогтбаатар гишүүнд өгөөрэй. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тийм хамгийн сайнаас нь Цогтбаатар гишүүнд өгөөрэй.

2 дахь санал хураалт. Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж дугаарыг 3 болгон өөрчлөх:

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэ, Авлигатай тэмцэх газар З.Дашидаваа-т тус тус үүрэг болгосугай.

Санал хураалт. Санал хураалт, Раднаасад гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: Энэ ерөнхийдөө авлигатай тэмцэх биш би өмнө нь уул нь дарга нарыг нь ирвэл юм ярья гээд байх юм. Авлигатай тэмцэх биш авлигаас урьдчилан сэргийлэх л хөтөлбөр байна. Энэ байдлыг чинь харахад. Энэний чинь гол оролцогч нөгөө шүүх, прокурор чинь энэ дотор юуг яг ямар хэлбэрээр туссан байгаа юм. Тэгэхээр энэ чинь ерөөсөө маш дутмаг байна.

Өчигдөр Хөгжлийн банкны хэргийг хар л даа. Бөөн амьтныг л ерөөсөө хамгийн гэм буруутай ёстой бүгдийг нь цаазлах л юм шиг л юм нийгмээр явуулж явуулж байгаад л төгсгөлд нь ихэнх нь гэм буруугүй гээд гарчихсан. Тэгээд танай мөрдөх байгууллага тийм хэмжээнд дутуу мөрдөж өгсөн үү, эс үгүй бол прокурор нь дутуу ажилласан уу, эс үгүй бол шүүх нь бүүр бүүр тэс хөндлөн ажилласан уу гээд. Энэнээс чинь харахаар тэр тэмцэнэ гэдэг чинь ерөөсөө л энэ гэмт хэргийг шийдэхээс эхлүүлээд л бүх юм явах ёстой юм шиг харагдах юм. Яах вэ авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлийн ажил чинь бол энэ дотроо ингээд ороод явж байхад нэг их яагаад байх алга. Одоо яг шүүх, прокурортой холбоотой зүйл, заалтууд жишээлбэл ингээд тогтоолоор ингээд үүрэг хүлээж байгаа Засгийн газар, Авлигатай тэмцэх газар хоёр дээр л юм явж байгаа байхгүй юу.

Яагаад энэ шүүх дээр, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эхлүүлээд нөгөө Сахилгын хороо, прокурор дээр яагаад юмнууд бичигдэхгүй байгаа юм. Энэ чинь эс үгүй бол энэ хөтөлбөрийн гадна явах юм уу. Өөр тусдаа хөтөлбөр явна гэж байхгүй санагдаад байх юм.

16 онд анхных нь хөтөлбөрийг нь батлаад явсан тэрний хэрэгжилт бол бараг бүрэн хэрэгжсэн байх гэж би танилцуулгаас нь уншиж байсан. Одоо энэ дээр, энэ 2 дээр ч юм уу. Энэ хаанаас орсон, ажлын хэсгээс оруулсан юм уу санал нь. Энэ дотор прокурор, шүүхтэй холбоотой зүйл, заалтууд орох уу. Өшөө нэмж, дахиад юм байгаа юу. Би эхнээс нь үзээд л яваад байна л даа энэ. Тусдаа юм байгаа юм байна тээ. Ерөнхийдөө зүгээр энэ дотроо ярихад энэ хуулийнхан л байх шиг байна, холбогдох байгууллагууд нь л байх шиг байна. Нийгэмд гаргаж ингэж жаал хүмүүс ялчхаад тэгээд шүүх дээр эцсийн байдлаар энэ гэм буруутай, бурууг нь ингээд ялгагдаад, гараад тогтоогддог. Тэгээд нийгэм эргээд юу гэж харж байгаа юм гэхээр өө энэ худлаа шүүчихлээ шүү дээ, худлаа мөрдчихлөө

шүү дээ гэдэг ийм л юм руу юм авааччихаж байгаа байхгүй юу.

Тухайн үедээ бол энэ мөрдөх байгууллага ёстой сайн ажиллалаа, прокурор сайн ажиллалаа, ингээд гэтэл шүүх тэнд энэ хэрэг мөн, энэ биш байна, энэ хүн буруутай байна, буруугүй байна гээд ингээд хоёрт хуваагаад шийдчихээр энийг чинь нийгэм эргээд л дахиад л наашаагаа муухай харж эхэлж байгаа байхгүй юу. Тэгээд ядаж байхад тэр зарласан, олон түмэнд гарсан хүмүүс нь жаал улс төр.../минут дуусав./

Б.Энхбаяр: Сайнзориг дарга хариулъя. 2 номерын микрофон.

П.Сайнзориг: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Өмнөх хөтөлбөр маань ерөнхийдөө тусгагдсан зорилтын 75 хувьтай хэрэгжсэн гэсэн ийм судалгааны үр дүн гарсан. Энийгээ бас зарим хэрэгжилт хангалтгүй болон бас хэрэгжүүлэх явцад бас үлдсэн энэ ажлууд энэ дээр тусаад явсан байгаа. Энэ хөтөлбөр маань өөрөө эргээд бас шүүх, прокурорын үйл ажиллагаатай, тэдгээрийн үйл ажиллагааг ил тод нээлттэй, хуульд нийцүүлэн явуулахад ямар уялдаатай байгаа вэ гэдэг ерөнхий ийм агуулгаар асуултыг асуулаа гэж ойлголоо.

Энэ яг уншсан санал хураах заалт дээр улсын, аймаг, нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд буюу улсын энэ хэрэгжүүлэх төлөвлөгөөнд ерөнхийлөн захирагч нарт гэдэг дээр шүүхийн төсвийг бас ерөнхийлөн захирч байгаа болон прокурор байгууллага, прокурорын ч гэдэг юм уу бүх байгууллагууд маань нэгдүгээрт хамрагдаж байгаа.

Хоёрдугаарт яах вэ яг энэ хөтөлбөрийн Улсын Их Хурлын тогтоолын хавсралтаар батлагдах хөтөлбөрийн маань 5 дугаар бүлэг дээр шүүх, прокурорын үйл ажиллагааг сайжруулах чиглэлд нэлээн тодорхой

зорилтууд бас орсон гэдэг зүйлийг хэлмээр байгаа.

Ер нь бол бас таны хэлж байгаа энэ шүүмжлэлүүдийг бас түрүүн бас Хууль зүйн байнгын хороон дээр бас хэлэлцүүлэг зохион байгуулах явцад бас Энхбаяр дарга хөндсөн. Бид бас намрын чуулганаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон ер нь зүгээр бүх процессын хуулиудыг бас тодотгож бас авч үзье. Ер нь зүгээр прокурорын энэ сахилга, ёс зүйн асуудал, дээрээс нь манай цагдаагийн байгууллагын ялангуяа мөрдөгч нарын бас сахилга, ёс зүйн асуудал, мэргэшсэн байдал, ур чадварын асуудал зэрэг олон асуудлуудыг ерөнхийдөө цогц байдлаар хөндсөн байдлаар хуулийн төслүүдийг бэлтгэж байгаа.

Энэ дээр мөрдөх албаны хуулийн бас судалгаа явагдаж байгаа. Цагдаагийн албаны хуулийн нэмэлт, өөрчлөлт, Прокурорын хуулийн нэмэлт, өөрчлөлт зэрэг бас энэ өнөөдрийн яг үүсээд байгаа сахилга, ёс зүйтэй холбоотой хэргийг, бас мэдээллийг ер нь зүгээр бас хардалтууд л байгаа. Яагаад ингэж алдаад байна. Тэгээд энэ нь яагаад, ямар байдлаар сэтгүүлч нарт очих вэ, ямар байдлаар улс төрч гэдэг юм уу тодорхой хүмүүст оччихоод байдаг вэ гэдэг дээр бас асуудлуудыг бас нэлээн анхаарч бас энэ чиглэлийнх нь зохицуулалтыг илүү их боловсронгуй болгоё гэдэг зүйлийг бас манай яаман дээр байгуулагдсан ажлын хэсгүүд ажиллаж байгаа гэдэг зүйлийг танд хэлье.

Мэдээж энэ хөтөлбөрийг цаашидаа 2030 он хүртэл хэрэгжүүлэхдээ шүүх, прокурорынхоо үйл ажиллагаатай уялдуулж хэрэгжүүлнэ.

Б.Энхбаяр: Одоо түрүүн би саналын томъёоллыг уншсан. 2 дахь саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Тогтоолын төслийн хавсралттай холбоотой санал.

1.Тогтоолын төслийн хавсралтын гарчгийн дараа доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, төслийн заалт бүрийн өмнөх “Үйл ажиллагаа” гэснийг хасах:

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдсан, 2023-2030 онд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгээд “сэргийлэх” гэдгийг найруулгаар “урьдчилан сэргийлэх” гэж томъёолъё.

2.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.1 дэх хэсгийн 1.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.4.Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор тогтоосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглож, хэрэгжилтийг хангана.

Раднаасэд гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: Хууль тогтоомжоор тогтоосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс

бусад тохиолдолд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно гэдэг нь юу гэсэн үг вэ. Зөвхөн хууль батлах, хэлэлцэх үед л юм ярьж бай, бусад үед ямар нэгэн байдлаар төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох гэдгээ яг юу гэж ойлгож байна. Ийш тийшээ бичиг цаас явуулаад энэ асуудалтай холбоотой юмнуудаа ирүүлээч гэвэл хөндлөнгөөс оролцсон болох уу, эс үгүй бол чуулганы хуралдаан дээр хэлэлцэж байгаа асуудлаар хэн нэгэн байгууллагын дарга цэрэгт удирдлагуудтай холбоотой, үйл ажиллагаатай нь холбоотой юм яривал хөндлөнгөөс оролцсон болох уу. Энэ яг ямар зорилгоор ийм өгүүлбэр орсон юм бол энэ.

Энэ ийм их ерөнхий мөртөө, энэ ч ингээд цаашилаад Их Хурал цаашилаад ер нь Их Хурал байх хэрэг байгаа юм уу, үгүй юү гэдэг л асуулт. Энэ хаанаас орсон санал юм. Чуулган дээр хүн хэлсэн юм уу, гишүүд хэлсэн юм уу энийг айн.

Б.Энхбаяр: Раднаасэд гишүүний асуултад би хариулчихъя. Энэ орж ирсэн төслөөрөө ийм байгаа юм энэ заалт. Улсын Их Хурлын гишүүн хууль тогтоох, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд төрийн байгууллагын үйл ажил үйл ажиллагаанд оролцохыг хориглож, хэрэгжилтийг хангана гэж байгаа юм. Энэ заалтыг нь найруулах буюу хууль тогтоох төрийн гадаад бодлогын үндсийг тодорхойлох, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах гэдгийг нь хууль тогтоомж Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор тогтоосон бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс гээд ухаандаа багцлаад, үйл ажиллагаанд оролцохыг хориглох гэдэг нь үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно гэдэг агуулгаар өөрчлөн найруулж тодотгосон юм.

Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Үгүй энэ Раднаасэд гишүүний хэлж байгаа чинь зөв байхгүй юу. Төсөл нь бараг дээр сонсогдож байна шүү дээ. Тийм бараг төсөл нь их зөв байхаар. Үгүй үгүй харин тэгэхээр ийм байна л даа. Зүгээр яах вэ тэрэн дээр төсөл дээр дутуу байгаа юм нь манай бичилт чинь ингэдэггүй. Хөндлөнгөөс оролцоно гэдэг чинь их тийм буруу үг байхгүй юу. Зүгээр хууль бусаар нөлөөлж, хөндлөнгөөс оролцох тухай хууль бус л гэдэг үг л байна уу гэхээс биш одоо орно шүү дээ энэ чинь. Их Хурлын гишүүд чинь бол хууль зөрчөөгүй л бол хууль тогтоогчийнхоо хувьд бол юм ярина шүү дээ. Тийм, зүгээр тэр хөндлөнгөөс оролцоно гэдгийг чинь ингээд тавьчихаар хууль ёсны дагуу бол энэ чинь оролцдог л хорвоо шүү дээ. Энэ чинь угаасаа л бүрэн эрхээ л хэрэгжүүлж байгаа юм чинь тийм.

Тэгэхээр энэ бол найруулга дээрээ болгоомжтой байхгүй бол хууль бусаар энэ хөндлөнгөөс нөлөөлөхийг л хориглодог болохоос биш, хөндлөнгөөс оролцохыг хориглоно гээд хэлчээд тэгээд үзэмжээрээ байгууллага нь чи хөндлөнгөөс оролцоод байна гээд байж болохгүй шүү дээ. Их Хурлын гишүүний үйл ажиллагааг тэд нар тодорхойлохгүй шүү дээ. Хууль зөрчсөн бол бид нар ёс зүйн болон хуулиараа хариуцлага хүлээдэг юм нь тусдаа. Жишээлбэл Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нь оролцоод л бид нар давхиад байгаа юм эд нар гэж байхгүй шүү. Жишээлбэл бусад байгууллагууд дээр.

Тэгээд хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс цаашидаа Монгол Улсын Их Хурлын гишүүн чинь хянан шалгах чиг үүргээ маш их хэрэгжүүлнэ гээд байгаа шүү дээ. Тэгээд хянан шалгах чиг үүргийн хүрээнд чинь бол байгууллагуудын үйл ажиллагаанд оролцож л таараа л даа. Гол нь хууль бусаар л тэнд хууль бус үйлдэл хийх, ёс зүйгүй үйлдэл хийж л оролцож болохгүй л гэдэг л хүрээ хязгаар байгаа болохоос биш түүнээс биш ингээд зүгээр ер нь

бүрэн эрхээ хэрэгжүүлнэ гэдгийг нь тэгээд хэн нэгэн хүн тодорхойлчихоод тэгээд тэрэндээ хөндлөнгөөс оролцож байна, оролцохгүй байна гэдэг асуудал тодорхойлбол тэр чинь эрхийг нь хязгаарласан л юм болно.

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Энэ 2 гишүүний хэлж байгаа зөв шүү. Ер нь байна шүү дээ. Энэ юунаас үүдэж гарч ирээд байна гээч Сүхбаатар гишүүнээ энэ сүүлийн үед парламент руу дайраад л ер нь парламент болохгүй юм хийдэг юм шиг болоод тэгээд энэ нь сүүлдээ зорилготой, зорилгогүй PR болж яваад одоо энэндээ тулж байгаа байхгүй юу. Энэ чинь байна шүү дээ цаад энэ суурь хандах хандлага өөрчлөгдчихөөд байгаа.

Тэгтэл Үндсэн хуулиараа энэ парламентын засаглалтай орон бөгөөд яг энүүгээрээ ороход энэ Үндсэн хууль зөрчинө. Яагаад гэвэл Үндсэн хууль дээр чинь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг заагаад өгчихсөн байгаа байхгүй юу. Тэр хүрээндээ л ажиллана шүү дээ угаасаа. Энэ чинь Үндсэн хууль байхгүй юу. Тэрийг янз бүрээр засах гээд, өөр органик хуулиар хязгаарлах гээд явна гэж байхгүй.

Харин тэр Үндсэн хуульд заагаад өгсөн бүрэн эрхээсээ хэтэрвэл энэ хууль бус. Тэр чинь угаасаа тэрэндээ хязгаарлагдаад заагдчихсан байж байгаа юм байхгүй юу. Тэгэхлээр энийг ер нь бүхэлд нь хасаж хаяад яагаад гэвэл Үндсэн хуулиараа энэ зохицуулагдчихсан юм байж байгаа юм. Энийг өөр байгууллагууд орж ирж оролдох гээд Улсын Их Хурлыг хөндлөнгөөс гэж юу яриад байгаа юм бэ энэ улсад Их Хурал ямар ч асуудлаар байр сууриа илэрхийлэх ёстой, хөндлөн биш байхгүй юу. Төрийн ямар ч байгууллагын хувьд, тийм төрийн ямар ч байгууллагын хувьд Улсын Их Хурал хөндлөн биш шүү. Тийм.

Б.Энхбаяр: Зарчмын зөрүүтэй саналын томъёолол та төгсгөлд нь гаргачих ажлын хэсгийн санал дуусангуут. Гишүүдтэй санал нэг байна. Тийм учраас саяын санал хураалгах саналыг ажлын хэсгээс шууд татаж авч, санал хураахгүйгээр шийдлээ.

3.Тогтоолын төслийн хавсралтын хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.2 дахь заалт. Энийг одоо үдчихсэн чинь. Заалтын “Улс төрийн” гэсний өмнө “Төрийн” гэж нэмж, “албан тушаалтныг” гэсний дараах “өөрийн” гэснийг “хувийн” гэж, зорилт 1.4 дэх хэсгийн 1.4.1 дэх заалтын “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж өөрчлөх. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.5 дахь хэсгийн 1.5.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.5.2.Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн явуулж байгаа бизнесийн салбарт давуу байдал олгосон хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Раднаасэд гишүүн, Сүхбаатар гишүүн нар асуулт асууна. Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Энэ чинь дахиад л нөгөө бид нар мөрдөх ёстой хуулиа дахиад зөрчсөн санал оруулчихсан юм биш үү. Зөвхөн төсөл санаачлах, санал гаргахаар энийг ярьж болохгүй байх. Энэ чинь бүүр санал хураалтад оролцохгүй гээд биччихсэн байгаа биз дээ. Зарим хууль дээр чинь сонирхлын зөрчилтэй асуудлаар. Тийм, тэгээд одоо тэгэхээр энэ чинь тэрийг чинь ахиад зөөллөөд хийчихсэн. Бүүр яг ярих юм бол энийг бүүр өшөө лавируулъя гэвэл бүүр үг

хэлэхийг нь ч гэсэн хориглох ёстой байхгүй юу.

Одоо энэ Боловсролын хууль дээр харж байна уу. Бөөн хувийн сургуулиудын нөлөө тэгээд энэтэй холбоотой асуудлууд дээр бас бөөн эмнэлгийнхэн, эмийнхэн орж ирээд л. Яг гадна талдаа харагдахгүй, бас цаад углуургаар нь юмыг нь мэддэг хүнд илт ойлгогдохоор л юмнууд явж байх байсан. Тэгээд тухайн төрлийн бизнес эрхэлдэг тэр салбарынх нь холбогдолтой хууль тогтоомж орж ирэх юм бол бүүр тэр хуралд ер нь оролцох шаардлагагүй болно. Үг хэлэхгүй, санал гаргахгүй бол тэгээд л тэр хүн хэрэггүй шүү дээ. Санал хураалтад оролцохгүй гэсэн заалт чинь хэвээрээ үйлчилж байгаа биз дээ одоо. Ашиг сонирхлоос ангид нийтийн эрх ашгийн төлөө байна гээд тангараг өргөхдөө л энийгээ цуг бид нар чинь яриад байсан биш билүү.

Тэгэхээр энийг бүүр дахиад зөөллөөд тавьчих юм. Төсөл санаачлах, санал гаргахаар ингээд. Тийм, энэ хуучин төсөл нь ямар заалт байсан юм.

Б.Энхбаяр: Би Раднаасэд гишүүний асуултад хариулчихъя. Энэ орж ирсэн төслийнх нь 1.5.2 нь бүүр Үндсэн хуультай зөрчилдсөн заалт байсан. Энийг бас чуулганы нэгдсэн хуралдаан дээр Нямаагийн Энхболд дарга бас Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга тухайлан бас уншаад энэ чинь Үндсэн хуультай зөрчилдөөд байна гэдэг асуудлыг бас ярьсан.

Яг энэ төслийн заалт нь ийм байгаа юм. Улсын Их Хурлын гишүүний өгсөн саналыг батлагдсан бодлого, шийдвэртэй нь уялдуулж хянах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж гээд энэ бүүр тэгээд олон нийтэд мэдээлнэ гээд бүүр нөгөө гишүүнийг өгсөн саналаар нь хариуцлага тооцох ч юм ишг ингээд ийм заалт болчихсон байгаа юм. Тэгэнгүүт нь энийг нь найруулаад энэ бол сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй нь уялдуулсан юм байна

гээд ажлын хэсэг дээр ярьж байгаад яг өөрөө би эцсийн өмчлөгчдийн бизнес эрхэлж байгаа компани нь хувь эзэмшиж байгаа тийм бас гишүүн байж болно шүү дээ. Тийм гишүүн байвал яг тэр бизнесийнхээ салбарт давуу байдал олгосон хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг нь хязгаарлаж гэдэг байдлаар өөрчилж найруулах ийм санал гаргаж байгаа юм.

Хэрвээ энэ санал дэмжигдэхгүй бол төслийн санал маань үлдэх буюу бүүр Үндсэн хууль зөрчсөн ийм санал нь үлдчих гээд байгаа юм. Хэрвээ гишүүд яах юм бол энэ төслийн заалтыг нь бүхэлд нь хасаж болно. Энэ санал дэмжигдэхгүй бол. Ер нь бүхэлд нь хасъя гэдэг зүйлийг гишүүд яах юм бол ажлын хэсэг саналаа татаад авч болж байна. Ийм хувилбар байгаа.

Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

Ж.Сүхбаатар: Яах вэ энэ заалт нь ажлын хэсгийн оруулсан нь байж байг. Харин гол нь юу вэ энэ үг нь бас буруу байна л даа. Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч эсвэл нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн явуулж байгаа бизнесийн салбарт давуу байдал олгосон гээд байгаа юм. Зүгээр л Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсвэл нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдтэй холбоотой тэр нь хууль тогтоомжид санал, санаачилга гаргахыг нь хориглох ёстой.

Тэгэхгүй бол давуу байдал олгосон гэхээр үгүй би давуу байдлыг нь багасгаж байгаа байхгүй юу, манай хуулийн этгээдийн хуулийн тогтоомжийг би сайн дураараа хүнд байдалд бий болгож оруулж байгаа гээд л ингээд л яриад явчихна.

Тэгэхээр давуу байдал олгосон бизнесийн салбарт гэдэг 2 үг чинь бол илүүдээд байна. Ер нь л өөрийнхөө хуулийн хувьцаа эзэмшиж байгаа тэр

эцсийн өмчлөгч байна уу, нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн төсөл санаачилсан, санал гаргахыг хязгаарлах л ёстой байхгүй юу. Ашиг сонирхлын зөрчлийн хуулиас урьдчилан сэргийлэх тухай хуульд зохицуулалт нь ерөнхийдөө байгаа л даа.

Гэхдээ нэг асуудал байхгүй байгаа нь үнэн. Төсөл санаачлахыг нь хориглоогүй, хязгаарлаагүй байгаа юм. Тэгэхээр энэ заалт тэр утгаараа ач холбогдолтой. Бизнесийн салбарт гэдэг үг хууль зүйн хэллэг биш шүү. Аж ахуйн, эдийн засгийн гээд үгнүүд байгаа шүү дээ. Өөрсдийнх нь эрхэлж байгаа аж ахуйн үйл ажиллагаа ч гэл үү ингээд үгнүүд байгаа шүү дээ. Давуу байдал олгосон гэдэг чинь хэрэггүй. Тэгэхээр би давуу байдал олгоогүй хуулийн төсөл, тогтоомжийн төсөл санаачилж байна гээд л явчихна шүү дээ.

Тэгэхээр зүгээр энэ агуулга нь бол бас зөв байх. Санаачлах эрхийг нь хязгаарлахгүй бол ингээд. Манай нэг гишүүн чинь л тодорхой компаниудыг барьж аваад л тэр нь ч хуурамч юм хийдэг, энэ нь ч тэгдэг гээд л зарлаад л бараг тэрүүгээрээ улс төр хийгээд байгаа юм уу, бизнес хийгээд байгаа юм уу, мань мэтийгээ татаж оруулаад байгаа юм уу. Энэ чинь сүүлдээ Их Хурлыг аж ахуйн үйл ажиллагааны өрсөлдөөнд давуу байдал олгодог талбар болгож хувиргаад байгаа байхгүй юу. Өөрсдөө санаачлах эрхээ ашиглаж.

Тэгэхээр ер нь бол энэ ямар нэгэн аж ахуй үйл ажиллагаа явуулдаг гишүүд бол энэ санаачилж байгаа энэ эрхийг урвуулан ашиглах явдал бол маш их аюултай юм байна лээ энэ хараад байхад. Сүүлийн үеийн явдлуудыг харахаар.

Тэгэхээр энэ бол харьцангуй, ялангуяа эцсийн өмчлөгч нөлөө бүхий хувьцаа эзэмшигч дээр санаачлах эрхийг нь хязгаарлах нь би бол зүйтэй. Тэгэхдээ ийм уут хийж өгмөөргүй байна. Давуу

байдал олгосон эд нар гээд. Тэгээд л хэлэхээр зэрэг би бүүр компаниа бүүр чангатгаж байгаа байхгүй юу. Давуу байдал биш бүүр дордуулах гээд хууль санаачилсан эд нар гэж ярих юм уу хаашаа юм. Тэгэхээр чинь ийм үг бол илүү.

Тэгэхээр энийгээ ингэж найруулаад, зүгээр энийгээ өөрчлөн найруулаад явбал зөв байх. Энэ бол цаашидаа ч гэсэн ер нь энэ би тэгж санаачилна шүү гэж ингэж сүрдүүлэх шинжтэй юм байна лээ шүү дээ. Ер нь бусад байгууллагуудыг хараад байхад. Эрхийг чинь тэгнэ, надад хууль тогтоох, санаачлах эрх байгаа гээд. Яагаад гэвэл Их Хурлын 1 гишүүн санаачилдаг байхгүй юу. Бусад оронд гурвуулаа, тавуулаа, долоо, наймуулаа нийлж байж санаачилдаг. Бид бол энд санаачлах эрх чинь хүчтэй тийм эрх мэдэл байгаа.

Тэгээд яах вэ татвар, бусад асуудлаар гишүүн санаачлах эрхгүй л дээ. Гэхдээ тэрийг тойруулаад л Компанийн хууль ч юм уу янз бүрийн аж ахуйн үйл ажиллагаатай асуудлуудаар цаашид энэ олон гишүүнтэй болж байна. Бас жоохон учрыг нь олохгүй бол энэ эцсийн өмчлөгчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа улсууд янз бүрийн сонирхол бас гарч магадгүй юм байгаа юм.

Б.Энхбаяр: Сүхбаатар гишүүний асуултад хариулахад тэр бизнесийн гэдэг нь аж ахуйн үйл ажиллагаанд гээд санал аваад явж болно. Энийг би дахиж уншиж болно.

Давуу байдал олгосон гэж бичихгүй болохоор ийм байгаа, болоод байсан юм. Энийг бас ярьсан юм ажлын хэсэг дээр. Зүгээр аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн төсөл санаачлахыг нь хязгаарлана гэхээр ер нь бүх хуулиуд ямар нэгэн байдлаар Монгол Улсын бүх аж ахуйн нэгжид хамаатай байгаад байгаа юм. Жишээлбэл Төсвийн хууль, Жишээлбэл Татварын хууль гэхэд л ерөөсөө бүх

салбар, аж ахуйн нэгжид хамаатай болчихоод байгаа юм. Газрын хууль гэдэг ч юм уу.

Тэгэхээр яг тухайлсан тэр бизнес, та сая юуны газрын тос хэлж байгаа бол яг тэр газрын тосны бизнес эрхэлдэг гишүүн өөрөө газрын тосныхоо тэр компанидаа давуу байдал олгосон хууль санаачлахгүй гэж шууд хэлж өгч байгаа л ухаантай. Тэгэхгүй болохоор ерөнхий аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох гэхивэл нөгөө бүх юманд хамаарах болчихоод байгаа.

Тэгвэл ингэж болж байна уу гишүүд ээ би нэг саналын томъёолол уншаадах уу.

1.5.2 Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээдийн явуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаа, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдох, эсвэл аж ахуйн үйл ажиллагааг хөндсөн холбогдох, холбогдох хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Ингэж болж байна уу. Энд агуулгаар санал хураагаад тэгээд ажлын дэд хэсэг энэний дэмжигдвэл найруулга дээр нь сууя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.6 дахь заалтын “сайжруулах” гэсний дараа “, хариуцлагыг нэмэгдүүлэх” гэж нэмэх. Санал хураалт асуулт.

Сандаг-Очир гишүүн горим гаргах уу. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Саяын хураалт дээр дэмжсэн санал өгсөн эсрэг санал гарчхаж. Хүчингүй болгож өгөөд дахин санал хураалгаж өгнө үү.

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүний гаргасан саналаар саяын санал

хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт 60 хувийн саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Одоо 5 дугаар санал хураалтаар санал хураалт явуулъя. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.1 дэх хэсгийн 2.1.2 дахь заалтын “хөгжүүлнэ” гэснийг “хөгжүүлж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэж, 2.1.5 дахь заалтын “төрийн албанд ёс зүйг төлөвшүүлнэ” гэснийг “чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлнэ” гэж, 2.1.7 дахь заалтын “төлүүлж, хяналт тавина” гэснийг “төлүүлэх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлнэ” гэж, “2.1.8” дахь заалтыг “2.4.2” болгон дугаарлалтыг өөрчилж, 2.1.3 дахь заалтын “гол” гэснийг, 2.1.7 дахь заалтын “бий болгож,” гэсний дараах “төрд учруулсан” гэснийг болон 2.1.4 дэх заалтыг тус тус хасах. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.2 дахь хэсгийн “механизмыг” гэснийг “тогтолцоог” гэж, 2.2.2 дахь заалтын “орчныг бүрдүүлнэ” гэснийг “зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж, 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалтын “зохих хэмжээний зарлагаа” гэснийг “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээний зарлагыг” гэж өөрчлөх. Санал хураалт асууя.

Раднаасэд гишүүн асуулт асууя. Санал хураалтыг цуцалж байна. Раднаасэд гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: 2.3.1 зохих хэмжээний зарлагаа мэдүүлэх гээд энэ

тэгэнгүүт тэрийг нь мөнгөн дүнтэй болгож байна тээ. 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээний зарлагыг гэж байгаа юм. Ийм юм байдаг юм уу Пүрэвсүрэн.

Б.Энхбаяр: Энэ Мөнхбаатар дарга. Саяын санал хураалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Мөнхбаатар дарга горимын санал гаргая.

Л.Мөнхбаатар: Горимын санал гаргачихъя. Санал хураалтыг дахин явуулж өгнө үү. Төхөөрөмж ажилласангүй.

Б.Энхбаяр: Мөнхбаатар гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Хүчингүйд тооцсон учраас 7 дахь саналаар санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.4.3 дахь заалт нэмж, мөн хэсгийн “хууль,” гэснийг хасах.

“2.4.3.Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан албан тушаалтнуудаас бусад хуулиар тогтоосон албан тушаалын халдашгүй байдлын хүрээг хязгаарлана. Санал хураалт. Санал хураалтыг цуцлъя. Санал хураалт шүү гишүүд ээ. Хураалт хураалт дэмжье.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 2.5 дахь хэсгийн 2.5.3 дахь заалтын “бүрэн цахимжуулна” гэсний өмнө “үе шаттайгаар” гэж нэмж, мөн хэсгийн “Төрд байгаа” гэснийг “Төрийн үйл ажиллагааны” гэж өөрчлөх. Санал хураалт.

Раднаасэд гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: Энд бид нар нэг юмыг яахгүй бол. Энэ халдашгүй байдал, бүрэн эрх хоёрыг арай өөр хэлбэрээр явуулж байхгүй бол одоо хэдийд нь бид нар энийг засах юм байгаа юм мэдэхгүй байна. Их Хурлын гишүүнийг түдгэлзүүлнэ гээд л дайраад байдаг. Яг үнэндээ халдашгүй байдлыг нь байлгахгүй болгохын төлөө л тэгж байгаа шүү дээ. Прокуророос ч юм уу хэрэг шалгахад саад учрууллаа гээд. Зүгээр халдашгүй байдлыг нь бүрэн эрх нь явж л байна. Өөрөөр хэлэх юм бол хуралдаа суугаад, саналаа өгөөд, ажлаа хийгээд л явна. Халдашгүй байдлыг нь зогсоочихдог л болмоор байгаа байхгүй юу. Зөвхөн халдашгүй байдлын асуудал.

Тэгээд энэний чинь цаана хоёр, гурван юм. Нэгдүгээрт энэ хуулийн байгууллагууд аваад явчихсан хүнээ өө буруугүй хүнийг авч явчхаад дараа нь ингэлээ гэж хэл аманд орохгүйн тулд хүн олдоход хэрэг олддог гэдгээр тохох гэж нэг оролдлого явдаг гэдэг юм уу нөгөө бас нэр хүндээ хамгаалах тийм юмнаас нь бас хамгаалж өгч байгаа байхгүй юу. Бүүр эсрэгээрээ. Буруу, зөрүүгүй юм байгаа бол гишүүн нь өөрөө очиж шалгуулаад, өөрөө бараг халдашгүй байдлаас өөрөө татгалзаж очиж шалгуулаад тэгээд буцаад ороод ирдэг ийм эрх зүйн зохицуулалтыг бид нар хийхгүй болохоор халдашгүй байдлыг нь ерөөсөө гэмт хэрэгтэй нь хамтад нь авч явчхаад байгаа байхгүй юу. Энийг чухам яаж энэ дотор хийх вэ. Ер нь ажлын хэсэг дээр юм ярьсан уу энийг ер нь.

Б.Энхбаяр: Тийм нэмж байгаа юм. Үгүй үгүй. Одоо яг яах вэ анхны ноорог дээр байсан юм. Тэгээд Засгаас хасаж

орж ирээд ажлын хэсэг дээр яах вэ би бас ингэсэн юм. Би бол нөгөө Үндсэн хуулийн үндэслэл яриад ажлын дэд хэсгийн гишүүд маань энэ бусад ийм олон албан тушаалтнууд бас ийм ердийн хуулиудаар ингээд ийм авах ёсгүй ийм юмнууд байна гээд. Тэгээд энийгээ нэг цэгцлэх ёстой ер нь. Тэгээд томьёолол нь бол яг тийм байгаа юм хүрээг нь хязгаарлана гэдэг байдлаар. Одоо шууд нэршээгүй. Энийг судлаад ингээд хүрээг нь хязгаарла, зарчмын хувьд хязгаарлая. Энэ бол бас арай хэтэрсэн байна. Тэгээд энийг хууль тогтоогч дараа нь Байнгын хороо өөрөө санаачлаад энийг ер нь хуулиуд дээр нь ярья гэсэн бодолтой байгаа юм. Энэ хүрээг нь хязгаарлах асуудлыг тийм.

Энэ саналын томьёоллоор 8 дугаар саналаар санал хураалт явуулъя. Үгүй санал хураагаагүй. Сая Раднаасэд гишүүн үг хэлсэн шүү дээ.

60 хувиар санал дэмжигдлээ.

9, хөөш 9-ийг, 9-өөр чинь сая санал хураачихлаа шүү дээ.

10.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 3.3 дахь хэсгийн 3.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.3.3.Ашигийн бус салбар дахь терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Техник хэрэгжилтийн зөвлөмжид нийцүүлэн ашигийн бус байгууллагыг хамруулна. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.6 дахь хэсгийн 5.6.2 дахь заалтын “хараат бус,” гэсний өмнө “улс төрөөс” гэж, 6.1 дэх хэсгийн 6.1.4 дэх заалтын “Хураасан,” гэсний өмнө “Хөрөнгө буцаасан,” гэж тус тус нэмж,

зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтын “хориглоно” гэснийг “хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж, зорилт 5.2 дахь хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчлөх. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12-т, Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “өгөх,” гэснийг дараах “мөнгө угаах,” гэснийг хасах. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

13.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.6 дахь заалтын “тооцно” гэснийг “тооцдог болох эрх зүйн орчныг бий болгоно” гэж өөрчилж, 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.8.Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгийг хураах нэмэгдэл ялын төрөл бий болгох асуудлыг судалж, санал боловсруулна.”. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

14.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.11.Хахууль өгсөн, зуучилсан хүн, хуулийн этгээд гэмт үйлдлээ илчилсэн, нотлох баримт гаргаж өгсөн, хамтран ажилласан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, чөлөөлөх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”. Санал хураалт.

Ажиллах л ёстой доо. Энэ сая Мөнхбаатар дарга. Би бас, минийх бас ажиллаагүй байна шүү дээ энэ чинь одоо.

Би энэ чинь дараад байхад яагаад ажиллахгүй байна. Карт нь уу. Харин тийм. Та ирцэд, сая бас Мөнхбаатар даргынх, минийх бас дараад энэ төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцох саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

60 хувиар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас 14 дэх санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт.

Раднаасэд дарга горимын санал гаргах уу.

Ш.Раднаасэд: Санал хураалтыг хүчингүйд болгож дахиж явуулж өгнө үү.

Б.Энхбаяр: Раднаасэд гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалт. 60 хувийн саналаар саяын саналаар хүчингүйд тооцлоо.

14 дэх саналаар дахин санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ.

60 хувиар санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.12 дахь заалтыг хасах. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

16.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.15.Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмж, үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 шалгуурыг хангаж, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид, энэ шууд Англиар

нь бичих ёстой юу. Хаалтан дотор, тогтоол дотор Англиар бичих ёсгүй байх аа. Тийм, шууд бичих ёсгүй байх. Энэ хаалт доторх байхгүй шүү. Англиар бичих ёсгүй, Монгол хэлээр бичих ёстой. Үзүүлэгчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлнэ. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.2 дахь хэсгийн 6.2.4 дэх заалтын “шийдвэрлүүлнэ” гэснийг “шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бататгана” гэж, 6.3.1 дэх хэсгийн “болгоно” гэснийг “болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж өөрчлөн, 6.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.2.5.Эдийн засаг, авлига, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг болон мөнгө угаах өндөр эрсдэлтэй гэмт хэргийг суурь гэмт хэрэгт хамааруулах, гэмт хэргийн шинж, зохицуулалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенц, олон улсын стандартад нийцүүлнэ.”. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.3 дахь заалтыг хасах. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “суллахгүй байх” гэсний өмнө “шүүхээс” гэж нэмэх. Санал хураалт.

Сандаг-Очир гишүүн горимын санал гаргая.

Ц.Сандаг-Очир: Саяын санал хураалт дээр дэмжиж санал өгсөн боловч эсрэг санал гарсан байна.

Хүчингүй болгоод дахин санал хурааж гэж өгнө үү.

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүний гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүйд тооцох горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувиар горимын санал дэмжигдлээ.

Одоо 19 дүгээр саналыг дэмжье гэсэн санаанд томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.12 дахь заалтын “механизмыг” гэснийг “үйл ажиллагааг” гэж өөрчлөн, 6.4.11 дэх заалтын “нэгжсийг” гэсний дараах “тодорхой тооны мөрдөгчтэйгөөр” гэснийг хасах. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.2.Тухайн жилийн Төсвийн тухай хуулийг эрх бүхий байгууллагаас боловсруулж өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлахдаа төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төвлөрүүлэх орлого, зарцуулах зардлыг нийт дүнгээр нь, түүнчлэн эдийн засгийн ангилал, төрөл, зориулалт тус бүрээр тусгана.”. Санал хураалт.

Энэ төсвийн ил тод байдлыг сайжруулах хүрээнд. Энэ төслөөс нь юу гэж өөрчлөн найруулж байгаа билээ. Яг энэ заалт 7.1.12. Энэ юу юм байна шүү. Энэ Төсвийн байнгын, Тэмүүлэн дарга чинь яагаад байгаа шүү дээ. Эдийн засгийн ангилал, төрөл, зориулалт бүрээр нь тусгадаг больё гэдэг агуулгаар үр

дүнд суурилсан төсөвтэй болъё гэдэг зарчим яриад байгаа шүү дээ. Төслийнх нь заалт нь их ерөнхий юм байна. Тэрийг нь задалж л бичсэн юм байна. Төсвийн хуульдаа нийцүүлж л томъёолсон юм байна. Төслөөрөө байх ч гэмгүй юм байна даа энэ чинь тээ. Тийм, санал дэмжигдсэнгүй.

22.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.8 дахь заалтын “жендерийн мэдрэмжтэй,” гэсний өмнө “хүний эрх,” гэж нэмж, 7.1.5 дахь заалтын “суурилж батлан” гэснийг “суурилсан эсэхийг хянах тогтолцоог бүрдүүлж,” гэж өөрчлөн, 7.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.11.Төсвийн захирагчийн албан тушаалд нэр дэвшигчдийг бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөөр өрсөлдүүлэх зарчмыг баримтлан сонгон шалгаруулж, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулж хэвшинэ.”. Санал хураалт .

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.1 дэх хэсгийн 7.1.13 дахь заалтын “төрийн аудитын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “гаргана” гэснийг “гаргадаг үйл ажиллагааг тогтмол болгоно” гэж өөрчлөх. Санал хураалт.

24.Тогтоолын. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 7.3 дахь хэсгийн “тусламж, тусгай сангийн” гэснийг “тусгай сан, гадаадын зээл, тусламжийн” гэж, 7.3.5, 7.3.6 дахь заалтыг 7.3.2, 7.3.3 болгон дугаарлалтыг өөрчилж, 7.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.4.Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.”. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 8.1.6 дахь заалт нэмэх:

8.1.6. би гишүүдэд тарааснаас түрүүн Мөнх-Оргил гишүүний нэмсэн редакцыг оруулж унших гэж байгаа шүү.

“8.1.6.Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлага, төрийн оролцоог үе шаттай бууруулж, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулахыг хязгаарлана.”.

Бас Цогтбаатар гишүүний гаргасан, санаачилсан бас тогтоолын төсөл явж байгаа. Энийг бас энд нэмж агуулгаар нь суулгая гэж байгаа юм. Санал хураалт.

Раднаасэд дарга санал гаргах уу. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Санал хураалтыг дахин явуулж өгнө үү.

Хоёрдугаарт энэ байна шүү дээ энэ бид нар Засгийн газарт сая асуусан юм уу энэ юугаа. Саналыг нь авсан юм уу. Шууд ингээд ингэнэ ингэнэ гээд хязгаарлах уу. Одоо би шинээр байгуулах гэдгийг юу гэж ойлгож байгаагаа хэлж өгөх үү. Нийлж нэгдэн шинэ аж ахуй нэгж байгуулахыг шинээр байгуулах гэнэ. Хоёр аж ахуй нэгжийг татан буулгаад нэгийг дундаас нь нэгийг байгуулахыг шинээр байгуулах гэнэ. Нэгийг нийлүүлээд, татан буулгаад нөгөөдхөд нь

нэгтгээд байгуулахыг бас шинээр байгуулах гэнэ. Хэрвээ тийм тохиолдолд Их Хурал ингээд тогтоолоор ингэчихсэн яг хуучнаараа явахаас өөр аргагүй гэдэг байдалд юм очиж байгаа юм. Таныг бол ерөнхийдөө шинээр дахиж ингэж аж ахуй нэгж байгуулахгүй гэдэг санааг чинь 100 хувь дэмжээд байна.

Гэтэл яг энийг чинь яг хэрэглэх явцад янз бүрийн алдаа гарах вий л гэж бодоод байгаа байхгүй юу.

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Тэгэхлээр энэ дээр ийм санаа явж байгаа. Юу гэхлээр угаасаа жишээлбэл Эрдэнэс Монгол гээд энэ чинь Монголын төрийн өмчит компаниудын удирдах том толгой компанийг анхнаасаа тийм зориулалттай байгаа биз.

Тийм учраас нэр нь хүртэл зүгээр Эрдэнэс Монгол байхгүй юу. Хөрөнгө оруулалтын викив гэж яриад байдаг. Тэрнийхээ хүрээнд энэ компани чинь өөрийн дотроо бүтэц, бүрэлдэхүүндээ шинэ компаниуд байгуулаад төрийн хөрөнгө оруулалт шаардсан аж ахуйн нэгжүүдийг байгуулаад явж болж байгаа бөгөөд энэ чинь тэр том корпорац өөрөө хэвдээ л байж байгаа байхгүй юу.

Түүнээс тэгээд тэгэх гэж байгуулчхаад энэнийхээ хажуугаар давхар параллель аягүй олныг байгуулаад яваад байгаа байхгүй юу. Дөнгөж саяхан хүртэл байгуулчихсан. Энийг л зогсоо гэж байгаа байхгүй юу. Түүнээс тэр толгой компани угаасаа тэр зорилгынхоо хүрээнд өөр компани байгуулаад явахыг хэн ч хориогүй, зогсоогоогүй шүү дээ. Яагаад гэвэл тэр том корпорац, аж ахуйн нэгж дотроо энэ багтаад л явж байгаа. Бусад орнууд ч гэсэн яг тийм юм хийгээд байгаа шүү дээ. Том компани нь өөрөө хөрөнгө оруулалтаа хийгээд л явж байгаа. Казахстанд “Казана газ” ч юм уу эс үгүй бол “Казана” сан гээд тэр чинь тэр хөрөнгө төрийн хөрөнгө

оруулалтуудаа өөрөө хийгээд явж байгаа байхгүй юу. Тэгээд тэрнийхээ хүрээний компанид энэ багтаад явахад бол асуудалгүй л гэж байгаа юм.

Б.Энхбаяр: Энэ асуудлыг ер нь бас чуулган дээр нэлээн олон гишүүд хөндөж байсан, хэлж байсан. Тэр дотроо тухайлбал Мөнх-Оргил гишүүн хөтөлбөрийг хэлэлцэх явцад ер нь дотоодын нийт бүтээгдэхүүнд тэр дотроо төсвийн зарлагад эзлэх төрийн оролцоо, жин бол маш их болчихлоо. Энийг бууруулахгүйгээр бид авлигатай тэмцэнэ гэж ерөөсөө ийм тунхаг ярьж болохгүй. Гол асуудал бол энэ хувийн хэвшлийнхээ оролцоог Үндсэн хуульдаа заасан чөлөөт зах зээлийнхээ эдийн засгийн чиг баримжаа руугаа бид нар одоо ёстой эргэлзэлгүйгээр дэмжиж, энэ бодлогын арга хэмжээнүүдээ авах учиртай гэдэг гол бодлогын асуудлыг тавьсан.

Тийм ч учраас Мөнх-Оргил гишүүний энэ бодлого санааг ажлын хэсэг бас ярилцаад ялангуяа энэ төсвийн зарлага энэ томорч байгаа, тэлж байгаа, дотоодын нийт бүтээгдэхүүнд энэ томорч байгаа ялангуяа төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг шинээр байгуулах замаар данхайлгаж байгаа, авлигажиж байгаа энэ асуудлыг бодлогын түвшинд үе шаттай энэ 7 жилийн дотор 2030 он гэхэд эрс бууруулья гэдэг бид нар улс төрийнхөө бодлогоо энэ хөтөлбөртөө шингээх ёстой гэдэг асуудлаа тавьж байгаа юм.

Яг одоо Раднаасэд гишүүн, сая бас бусад гишүүдийн хөндөж байгаа шууд энэ асуудлыг хэрхэн, яаж зохицуулах вэ гэдэг маань энэ оны намрын чуулганаар хэлэлцэх Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулиудаар нарийн зохицуулагдана энэ асуудал нь хууль зүйн хувьд, хуулиар.

Тийм учраас Улсын Их Хурал бол ямар ч байсан авлигатай тэмцэх хүрээнд энэ асуудлаа бодлогын түвшинд бид ийм

зорилт тавьж байгаа шүү Засгийн газраа гэдэг тэр манлайллаа энэ хөтөлбөртөө заавал шингээх бодлогын асуудлаа суулгах гэж байгаа гэдгийг, суулгах нь зүйтэй гэж бас ажлын хэсэг дээр ярьж ингэж оруулж ирсэн байгаа шүү.

Одоо санал хураалт явуулна. Тэгээд гишүүд орж ирээрэй. Авлигатай тэмцэх хөтөлбөр дээр гишүүдийн хувьд, ялангуяа Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн манлайлал, оролцоо их чухал байгаа. Гишүүд орж ирээрэй.

Яг одоо саяын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

26.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 8.1 дэх хэсгийн 8.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт хүргэх, Тийм энэ саяын санал дэмжигдвэл энийг хураахгүй гэж 2 хувилбараар бэлдсэн байсан юм ажлын хэсэг. Тэгэхээр 26 болж байна тийм ээ.

26.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 9.4 дэх хэсгийн 9.4.2 дахь заалтын контенг шүүлтүүртэй” гэснийг хасах. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

27.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 9.5 дахь хэсгийн 9.5.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.5.1.Төрийн албан хаагч, удирдах албан тушаалтнуудад авлигын эсрэг сургалтыг үе шаттай зохион байгуулах, ёс зүй, манлайллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.”. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

28.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай Зорилго 11 нэмэх:

“Зорилго 11.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог сайжруулна.

Зорилт 11.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн зохион байгуулалт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлнэ.

11.1.1.Монгол Улсын Засгийн газар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, санхүүжүүлнэ. Яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Засгийн газар хариуцан ажиллана.

11.1.2.Авлигатай тэмцэх газрын бүтцэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмж өгөх, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх чиг үүрэг бүхий Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх Ажлын алба ажиллана.

11.1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт хариуцсан байгууллагууд хэрэгжилтийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлнэ.

11.1.4.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар нь Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн, санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

11.1.5.Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тайлан, үнэлгээ, санал, дүгнэлтийг хэлэлцээж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, ажлаа эрчимжүүлэх талаар чиглэл өгч болно.”. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо найруулгын саналаар санал хураана.

1.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “төлбөргүй” гэсний өмнө “үнэ” гэж, 9.2 дэх хэсгийн 9.2.1 дэх заалтын “төлөвшүүлнэ” гэсний өмнө “олон нийтэд” гэж, 9.4.4 дэх заалтын “Боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмэх. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.5 дахь хэсгийн 1.5.3 дахь заалтын “зохицуулалт, механизмыг” гэснийг “зохицуулалтыг” гэж, 2.1.2 дахь заалтын 3.1.3 дахь заалтын “тавих” гэснийг “тавигдах” гэж, 3.2.4 дэх заалтын “иргэдийн шууд хяналт, мониторинг хэрэгжүүлэх” гэснийг “иргэд шууд хяналт тавих боломжийг” гэж, 3.3.2 дахь заалтын “дэмжлэг” гэснийг “тусламж” гэж, 5.1.4 дэх заалтын “авлигын гэмт хэрэг, зөрчлийн болон” гэснийг “авлигын болон зөрчлийн гэмт хэргийн” гэж, 5.1.6 дахь заалтын “батлагдсан төсвийн хэмжээнээс” гэснийг “батлагдсан төсвөөс” гэж, 5.4.4 дэх заалтын “хүний нөөцийн чадавхыг бий болгоно” гэснийг “хүний нөөцийг бэхжүүлнэ” гэж, 6.2.3 дахь заалтын “яллах ажиллагаан дахь” гэснийг “яллах ажиллагааны явцад” гэж, “эзэмшүүлнэ” гэснийг “эзэмших нөхцөл боломжийг бий болгоно” гэж, 6.2.4 дэх заалтын “гадаад оронд” гэснийг “гадаад улсад” гэж, 6.4.5 дахь заалтын “ил тод байдлыг бий

болгох” гэснийг “ил тод байдлыг бий болгоно” гэж, 6.4.9 дэх заалтын “санхүүгийн мэдээлэл,” гэснийг “санхүү, орлогын эх үүсвэрийн” гэж, зорилт 7.1 дэх хэсгийн “Төсвийн төлөвлөлтийг” гэснийг “Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог” гэж, “оролцоог хангаж, тогтолцоог” гэснийг “оролцоог хангах замаар” гэж, 7.2.2 дахь заалтын “зохион байгуулж” гэснийг “зохион байгуулдаг тогтолцоог бүрдүүлж,” гэж, 7.2.3 дахь заалтын “данснаас хассан” гэснийг “данснаас хасагдсан” гэж, 7.4.3 дахь заалтын “цахим хэлбэрт бүрэн шилжүүлнэ” гэснийг “бүрэн цахимжуулна” гэж, 8.4.2 дахь заалтын “нээлттэй сонсгол” гэснийг “нийтийн сонсгол” гэж, 9.3.1 дэх заалтын “Бүх шатны сургалтын” гэснийг “Бүх түвшний сургалтын” гэж, 9.4.3 дахь заалтын “зүйлсийг бууруулах дүн шинжилгээ хийнэ” гэснийг “зүйлсэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 1.2 дахь хэсгийн 1.2.1 дэх заалтын “эдгээрийг амлах” гэсний өмнөх “эхсүл” гэснийг, 2.4 дэх хэсгийн “хууль,” гэснийг, 5.4.4 дэх заалтын “шаардлагатай” гэснийг, 6.2.3 дахь заалтын “олон улсын” гэснийг хасах. Санал хураалт.

Энэ миний санал хураалт, энэ миний кноп ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцох горимоор санал хураалт явуулъя

Саяын 60 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Найруулгын 3 дахь саналаар дахин санал хураалт явуулъя.

Өө энэ болохгүй байна тээ. Мөнхбаатар гишүүн горимын санал гаргая.

Л.Мөнхбаатар: Дэмжсэн санал өгсөн болов чиг төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Б.Энхбаяр: Хүчингүйд тооцъё. Мөнхбаатар гишүүний гаргасан саналаар дахин санал, горимын санал. Хүчингүйд тооцох горимын санал. Санал хураалт.

60 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Одоо 3 дугаар саналаар дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сая найруулгын саналын 2-т хураасан 5.1.4 дэх заалтын “авлигын гэмт хэрэг, зөрчлийн болон” гэснийг “авлигын болон зөрчлийн гэмт хэргийн” гэж найруулгын саналаар санал хураасан. Энэ найруулгын саналыг хүчингүйд тооцъё.

Яагаад гэхээр төслийн заалт нь зөв байна. “Авлигын гэмт хэрэг, зөрчлийн болон” гэдэг нь зөв байна. Тэгэхгүй “авлигын болон зөрчлийн гэмт хэрэг” гэхээр зөрчлийн гэмт хэрэг гэдэг ойлголт байхгүй.

Тэгэхээр найруулгын саналаа саяын хураасныг хасъя гэдэг саяын уншсаныг.

“Авлигын болон зөрчлийн гэмт хэргийн” гэж найруулах гэдгийг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс

дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт дууслаа.

Одоо Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд танилцуулъя.

Их Хурлын гишүүн Мөнхбаатар, Цогтбаатар нарын гаргасан саналын томъёолол байна.

Тогтоолын төслийн хавсралт дахь зорилго 1-ийн зорилт 1.1 дэх үйл ажиллагаа 1.1.4 дэх заалтыг хасах. Санал хураалт. Одоо ганцхан санал.

60 увийн саналаар санал дэмжигдлээ.

Мөнх-Оргил гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй санал байна.

1.“Зорилго 8”-ыг “Зорилго 3-аар” байрыг нь сольё гэсэн. Өөрөөр хэлбэл энэ төрийн өмчийн компанийн засаглал, ил тод байдал, төрийн оролцоог багасгах. Түрүүн уншсан тэр асуудлын ач холбогдлыг ер нь нэлээн том байх ёстой энэ үндэсний хөтөлбөрийн хамгийн гол асуудал бол. Тийм учраас тэр хойно 8-д биш дарааллыг нь л солих гэж байгаа юм. 3-т нь бичих ёстой гэсэн. Тэгээд 3-т байгаагаа 8-д бичье гэдэг ийм санал байна. Санал хураалт.

40 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар уншина. Дараагийн асуудалдаа оръё.

12.41 цаг

Гурав. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93.1-т Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтанд саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаар хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж, мөн 93.3-т нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно гэж заасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хуралдаанд саяын ажлын хэсэг байна. Хэвээрээ байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор үг хэлж дууслаа.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор энэ чинь юу юм байна шүү дээ. Горим гаргах билүү.

Тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь гишүүд санал гаргаагүй учраас анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн батлах үе шаттай хамт явуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ ажлын албыг нь байгуулж өгөхгүй бол ажлын алба нь байхгүй байгаад байгаа юм. Саяын хөтөлбөрийнхөө ажлын алба орхичихсон юм байна лээ. Тэх дэмжиж дэмжиж. Ажлын алба байгуулж байгаа.

60 хувийн саналаар санал горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул “Тогтоолд өөрчлөлт оруулах” тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

12.44 цаг

Монгол Улсын Дээд шүүхийн 2024 оны төсвийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Улсын дээд шүүхээс Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Эрдэнэчимэг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, Эрдэнэцэцэг Улсын дээд шүүхийн Төсвийн асуудал хариуцсан ахлах референт нар оролцож байна.

Улсын дээд шүүхийн 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Дээд Шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр танилцуулна. 2 номерын микрофоныг урьж байна.

С.Заяадэлгэр: Сайн байцаана уу. Эрхэм Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны төсвийн төслийн танилцуулгыг та бүхэнд дэлгэрэнгүйгээр танилцуулсан тул товч танилцуулъя.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар шүүх эрх мэдлийн бие даасан төсөвтэй байх, шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангах, төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд бууруулахгүй байх гэх мэт хуульд заасан Шүүхийн тухай хуульд заасан зарчмуудыг баримтлан, мөн Улсын их Хурлаас батлагдсан “Алсын хараа-2050” болон “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан шүүх эрх мэдлийн салбарын хөгжлийг хангах талаарх заалт, зорилтуудад нийцүүлэн 2024 оныхоо төсвийн төслийг боловсрууллаа.

2021 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүхийн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт бас орсон. Хууль тайлбарлах болон хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, онол практикийн судалгаа, шинжилгээнд үндэслэн шийдвэрүүдийг гаргах, Үндсэн хуульд заасан шүүн таслах ажиллагааны болон шүүн таслах ажиллагаанаас бусад чиг үүргүүдийг

хэрэгжүүлэхэд хэвийн нөхцөлийг хангах, мөн нийт шүүхийн системийн сургалт, судалгаа, мэдээллийн үйл ажиллагааг эрхлэн хариуцдаг Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагааны төсөв бас энэ хүрээнд багтсан байгаа.

Улсын дээд шүүх нь 21 онд 4118 хэрэг хянан шийдвэрлэсэн бол 2022 онд 4490 хэрэг хянан шийдвэрлэх шийдвэрлэсэн. Дээд шүүхээс Үндсэн хуулиас бусад хуулийн тайлбар батлах үйл ажиллагааны хүрээнд өнгөрсөн хугацаанд 12 хуулийн тайлбарыг, албан ёсны тайлбарыг батлаад байна.

Дээд шүүхийн үйл ажиллагаанд шинэ тутам тулгамдаж байгаа нэг асуудал шүүн таслах ажил ажиллагаа болон энэ тайлбар батлах энэ бүх үйл ажиллагаа судалгаа, шинжилгээнд үндэслэн хийгддэг болсон учир Улсын дээд шүүхийн судлаач туслахуудын 3 хүртэл судлаач туслахтай байхаар шинэчлэн батлагдсан Шүүхийн тухай хуульд заагдсан. Энэ хүний нөөцийг бүрдүүлэхэд бас тавигдах шаардлага бол өндөр байгаа. Мөн энэ судалгаа, шинжилгээний туршилагатай боловсон хүчнийг сургаж бэлтгэх, чадавхжуулахад бас энэ сургалтын хэрэгцээ шаардлага энэ тэр бас нэмэгдэж байгаа.

Дээд шүүхийн энэ судлаач туслахууд бол өнгөрсөн хугацаанд энэ саяын хэлсэн үйл ажиллагаатай холбоотой 160 гаруй судалгааг хийсэн байдаг. Тэгээд Монгол Улсын хэмжээнд 800 гаруй мянган шүүхийн шийдвэрүүд, энэний бас төсөөтэй хэрэглээ судлах шаардлагууд бас байдаг. Ингэхээр практик судалгаан дээр нэлээн их ажил Тамгын газрын хувьд тулгардаг. Ингээд цааш энэ дээр бид нар бас цахимжилт, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх үүднээс төсөл боловсруулсан.

Гэхдээ улсын төсөв дээр хөрөнгө оруулалт Улсын дээд шүүх дээр тусгагдаагүй. КОЙКА буюу олон улсын

төсөлд энэ цахимжилтынхаа тал дээр төслөө илгээгээд байна.

Ер нь нийт төсвийн 71 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын зардал эзэлж байгаа. Бусад зардлын хувьд ашиглалт, урсгал засвар, томилолт, төлбөр хураамж гэх мэт ийм зардлууд тусгагддаг.

Энэ жилийн төсөв дээр онцлог орж ирж байгаа нь Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн шинэчлэн байгуулагдаад эхний жилдээ 50 хувийн орон тоотой явсан бол 24 ондоо 100 хувийн орон тоотой ажиллах шаардлагыг нэмж тусгасан байгаа.

Бусад зардлуудын хувьд ер нь цалингийн өсөлтийн сүлжээгээ баримтлаад тусгасан, тариф зардлуудыг тарифын дагуу тусгасан. Зарим зардал дээр үнийн өсөлтийг харгалзан тусгасан байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Баярлалаа. Улсын дээд шүүхийн 2024 оны төсвийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс үнэлгээ хийсэн. Энэ үнэлгээг хэн танилцуулах вэ. Тараачихсан байгаа тээ. Тийм дэг байхгүй юм байна тээ.

Гишүүдэд Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний юуг тараасан байгаа юм байна. Энэтэй холбоотойгоор гишүүдээс асуух асуулт байна уу. Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Энэ Улсын дээд шүүх гээд бас юун олон шинжээч, судлаач болчхов. Гурав гурван шинжээч, судлаачтай байх ёстой ч гэнэ үү. Тэгээд Улсын дээд шүүх маань ер нь шүүх маань хараат бус ажиллах ёстой л доо. Тэрнийх нь хараат бус ажиллах тэр зардал чирэгдэл тэр бүх юмнуудыг нь

хангаж өгөх ёстой гэж ойлгож байна. Хуулиараа тийм байгаа.

Тэгээд энэ Улсын дээд шүүх маань өөрөө хараат бус ажиллаж чаддаг юм уу. Энэ Тамгын газар нь Улсын дээд шүүхээ энэ төсөв мөнгөнөөс хараат бус ажиллаж чадаад ингээд байна гэж ойлгож байгаа юу. Энэ төсөв мөнгийг нь тэгээд наад шинжээч, судлаач тэр хуулийг нэг мөр хэрэглэх энэ юманд нь тэгээд хэрэглээд ингээд явж чадах уу. Сая ингээд юу яаж л байна л даа тэр Хөгжлийн банкны хэргийг энэ ямар, Соёлын төв өргөөнд шүүгээд байв уу. 60, 70 хоног л шүүж байна гээд явлаа. Тэгээд ингэж зориулалтын бус байранд шоу маягтай ингэж хийж болж байгаа юм уу. Тэрийг би тэгээд ойлгоогүй. Тэр хууль, хяналтын байгууллага, прокурор энэ юм нь буруу, зөв ажиллаад байдаг юм уу эсвэл шүүх нь ингэж ажиллаад байдаг юм уу баахан татвар төлөгчдийн мөнгө, эцэст нь ингээд ард түмэн л буруутай болоод үлдэх үү. Тэгээд хараат бус шүүж чадаж байна гэж үзэж байна уу. Тэгээд 80 хүн ороод тэрнээс одоо энэ 20, 30 нь л гэм буруутай, бараг 60, 70 хувь нь гэм буруугүй болж гарч ирж байна л гэж байна.

Тэгэхээр одоо энэ прокурор, мөрдөн байцаах энэ хууль хяналтын байгууллага нь буруу ажиллаад ийм юм оруулж ирсэн байна уу, эсвэл шүүх нь ингэж ажиллаад байдаг юм уу. Ингээд төсөв төлөвлөгөөгөө нэмүүлье гээд л ингээд орж ирж байгаа юм. Энэ эрх баригчдын дохио зангаагаар ажиллаж байна уу. Тэр хэнийг нь ялла гэснийг нь яллаад, яллахгүй гэснийг нь болиод ингээд яваад байна уу.

Тухайлбал би тэр энэ хэдэн тэрбумаар нь идэж уучихсан энэ юм ингээд өнгөрч байхад тухайлбал би Мөнх-Эрдэнийг ярих гэж байна. Манай Ардчилсан намын бүлгийн зөвлөх, миний зөвлөхөөр ажиллаж байсан тэр хүн ял аваад ингээд хоригдоод байдаг. Тэр тэгээд эцсийн эцэст энэ ард түмэн л буруутай юу. Татвараа төлнө, дээр нь нэмж хулгай хийлгэнэ. Тэгээд хараат бус

шүүх энэний юу билээ Хөгжлийн банкны сонсгол зөндөө л хийсэн шүү дээ. Хэдэн тэрбумаар нь ингээд л идчихсэн, хэдэн их наядаар нь идчихсэн. Тэгээд энэ бүх юманд ингээд дуугүй байж байдаг, шүүх нь ингэж ажиллаж байдаг. Эсвэл одоо тэр хүмүүсийг хэлмэгдүүлээд тэр прокурор, мөрдөн, Авлигатай тэмцэх газар нь ажиллаад ингээд ороод ирсэн юм уу. Хэн нэг нь энэ дээр хариуцлага хүлээмээр байна шүү дээ. Тэгээд нэмээд баахан мөнгө төгрөг нэмээд л шинжээч, судлаач авна ч гэх шиг.

Ер нь эхлээд шүүх өөрөө тэр байгаа юмандаа тааруулаад аятайхан ажиллаж чадаад дараа нь тэгээд мөнгө төгрөг энээ тэрээ юмаа нэмүүлбэл яасан юм бэ. Угаасаа тэр 24 оных нь юмыг тусад нь энэ тэр гээд л яаж байснаас тэр байшин барилга энээ тэрээ юмыг нь нөхцөлийг нь хангах иж бүрэн юмыг нь ингэж шийдэж оруулж ирэхгүй бол тэр шинжилгээ судалгааны байгууллага нь хэдэн төгрөг нэмж байна гээд л, шинжээч, судлаач авна гэдэгт нь 5, 10 төгрөг нэмнэ гээд л. Ингэж дэмий байх. Тэр анхан шатынхаа шүүгчдээ, тэр шаардлага хангасан шүүхийн байрандаа энэ юмандаа мөнгө төгрөг зарцуулсан нь дээр байх.

Б.Энхбаяр: Монгол Улсын бүүр бусад Улсын дээд шүүхээс бусад бүх шатын шүүхийн төсөв бол 2 дахь асуудал буюу Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөвт багтаж яригдана. Таны хөндөж байгаа нөгөө бусад шүүхийн байр, тасалгаа энэтэй холбоотой.

Ганбат гишүүний хөндөж хэлсэн энэ шүүгчдийн олон туслахууд шинээр нэмж авах гэж байгаа гэдэг дээр би бас санал гаргах гэж байгаа юм Ганбат гишүүнээ. Энийг туслахууд, судлаач туслах гэдэг орон тоог ийм олноор нэмэх шаардлагагүй байна гэсэн ийм санал гаргах гэж байгаа. Та санал хураах дээр нь бас дэмжиж өгөөрэй гэдэг ийм саналтай байгаа.

Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо Улсын дээд шүүхийн 2024 оны төсвийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд нь нэрсээ өгнө үү. Алга байна. Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Одоо шүүх маань ерөөсөө шүүх шиг ажиллаж тэр Үндсэн хуулийн хүрээнд, шүүхийн бие даасан хараат байдлаа хангаж ингэж ажилламаар байна. Тэгэхгүй бол бид нар шүүхтэй ч юм шиг, хуультай ч юм шиг. Тэгээд тэр хуулиа биелүүлэхгүй хуулийн тэр хамгийн эцсийн юм шүүх дээр л очиж байгаа шүү дээ. Тийм байхад хүний эрх хангагдаж байна, биелэгдэж байна гэж ярих аягүй хэцүү болчхож байгаа юм.

Тэгээд тэр ялгаж, салгаж өгдөг шүүх нь ийм байдалд орчихсон. Ерөөсөө хэн эрх мэдэлтэй, хэн албан тушаалтай, хэн мөнгөтэй ийм улсад л үйлчилж байна шүү дээ. Тэдний талд л шийдвэр гаргаж өгч байна шүү дээ. Энийг би хэлээд байгаа юм биш л дээ. Энэ гадуур олон нийт л байнга хэлж, ярьж байна. Эндээ та бүхэн дүгнэлт хиймээр байгаа юм.

Мэдээж хэрэг тэр бүх нөхцөл бололцоог нь хангаж ажилладаг Улсын дээд шүүхээсээ эхэлмээр байгаа юм. Улсын Дээд шүүхийн Тамгын газар нь байх шиг байна. Тэрийг тэгээд цааш нь хэлж, ярьж энэ юман дээрээ анхаарсан нь дээр байх. Тэгэхгүй бол энэ 3 засаглалын нэг нь болох хараат бус ажиллах ёстой. Энэ Улсын дээд шүүх бүүр бүрэн дампуурчхаад байна гэж ойлгож байна. Бид нар бол шүүхтэй л юм шиг байгаагаас биш яг шүүх тэр бүрэн утгаараа хуулийг биелүүлж, хуулийг дээдэлж, ингэж ажиллаж байгаа юм байхгүй, нэр хүнд нь унтчихсан ийм байдалд байна. Энэ дээр анхаарал тавьж ажиллах ёстой л гэж ойлгож байна. Энэ бол хэрээс хэтэрч байна. Энэ талаар дуугардаг барьдаг хүмүүс чинь улам л цөөрч байна. Хэлээд яриад байхад нэмэр байхгүй гэсэн ийм байдалд орж байна. Энэ маань Монгол Улсын Үндсэн хууль, ард түмэнтэй байгуулсан гэрээ энэ бүх

юм чинь зөрчигдөж байна гэдэг дээр хатуу анхаарах хэрэгтэй байгаа юм.

Тэгээд бид бүхэн тэр мөнгө төгрөг энэ тэр юмаа энэ боломжтой хэмжээнд ажиллах хэмжээнд нь тавьчих ёстой. Тэр дээр анхаарах ёстой. Тэрнээс биш эрх баригчдын юм уу, мөнгөтэй төгрөгтэй ч юм уу, хэн эрх мэдэлтэй тийм хүмүүсийн дохио зангаагаар ажиллачхаад тэрнийхээ дагуу 5, 10 төгрөг нэмүүлдэг ч юм уу, хэдэн хүн судлаачаар нэмж ажилд авчих иймэрхүү маягаар ингэж явахгүй байсан нь дээр гэж ойлгож байна. Тэрийг Энхбаяр дарга санал гаргах юм байна. Би нэгдээд тэрийг нь дэмжээд явсан нь дээр. Гол юман дээрээ бол анхаарал хандуулж ажиллах цаг болсон байна шүү гэдгийг хэлье.

Б.Энхбаяр: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо Улсын дээд шүүхийн 2024 оны төсвийн төсөлтэй холбоотойгоор холбогдуулан саналтай гишүүн байна уу.

Би байгаа. Энэ урьд өмнөх жилийн Байнгын хороод, энэ чинь ийм юм байна лээ Төсвийн, Улсын Их Хурлын Тамгын газрын энэ сая гишүүд тараачихсан байгаа хяналт, шинжилгээ гээд танилцуулгаа тавьчихсан байгаа. Эндээс улбаалаад нөгөө зарчмаар нь санал хураалгаад явчихдаг байсан юм байна лээ. Яг тоон дүнг чинь дараа нь энэ хүмүүс яг тулгаж хянадаг тоон дүнг нь зарчмаар нь. Тэгэхээр би яг зарчмаар санал хураалгах гэж байгаа юм.

Ерөнхийдөө Тамгын газрын танилцуулснаар Улсын дээд шүүх өмнөх оныхоосоо тийм айхтар зардал нэмж, хөрөнгө оруулалт юман дээр айхтар нэмсэн юм гайгүй байгаа юм. Цалингийн нэмэгдэл угаасаа нэмэгдэж байгаа. Шинэ Хангарьд ордонд чинь нүүх ажил явж байгаа. Энэтэй холбоотой шүүх хуралдааны байдлаар шинэ танхимуудаа янзлах ёстой, засвар хийх ёстой тийм асуудал байгаа.

Тийм учраас энэ байр ашиглалттай холбоотой тэр зардлыг нь дэмжих ёстой юм байна гэж ойлгосон. Шүүхийн тухай хуульд зааснаар Улсын дээд шүүх дэргэдээ Шүүхийн сургалт, сурталчилгаа, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй бий болсон. Энэ нь болохоор зөвхөн Улсын дээд шүүхийн биш Монгол Улсын бүх анхан, давах, бүх шатын шүүхийн сургалт, сургалтын хүрээлэн нь Дээд шүүхийнхээ харьяанд ирчхээд байгаа юм.

Энэ орон тоог нь болохоор анх байгуулснаас нь хойш 2 жилийн хугацаанд ер нь бүтэн орон тоогоор баталж өгөөгүй. 30, хэдэн тийм ингээд үе шаттай нэмэгдүүлж явъя, хөрөнгө мөнгөний ийм бололцоо байхгүй байгаа учраас гэдгээр одоо бол 50 хүрэхгүй хувьтай, хувийн орон тооны байдалтай явж сая 2 жил ирсэн байгаа юм.

Тийм учраас энэ хүрээлэн, судалгаа шинжилгээний хүрээлэн их үр дүнтэй байгаа нь ер нь Дээд шүүхийн сүүлийн 1 жилийн гаргаж байгаа тайлбаруудаас их харагдаж байгаа. Тайлбарууд ер нь өөр болж байгаа. Онолын маш сайн суурь судалгаатай хийгдэж байгаа тайлбарууд нь. Ийм болж байгаа нь Улсын дээд шүүхийн сүүлийн 1 жилийн хугацаанд гаргаж байгаа тайлбаруудаас илтэд анзаарагдаж байгаа. Илтэд. Нэг хуулийн нэг заалтыг тайлбарласан тайлбар гэхэд л доод тал нь 10 хэдэн хуудас бүүр ийм онолын суурь судалгаатай болж байна гэдэг энэ бол бидний анх бодож байсан Дээд шүүх онолын шүүх болох тэр чиг хандлага руугаа ороход нь энэ Сургалт, судалгааных нь хүрээлэн маш их үр дүнгээ өгч байгаа юм байна гэдэг нь харагдаж байгаа.

Тийм учраас энийг нь тэр бүрэн орон тоогоор ажиллуулах талд нь дэмжээд, харин тэр улсын дээд шүүгчид судлаач туслахтай болно гэдэг энийг нь Ганбат гишүүн бид 2 хасъя гэдэг Дээд шүүгчдийн хувьд. Энэ тийм судлаачид нь л хэрэгтэй яг энэ туслах бол хэрэггүй байна, шаардлагагүй гэдэг ийм санал

гаргах гэж байгаа юм. Туслахуудыг нь орон тоог дэмжихгүй гэдэг би хасъя гэдэг шууд санал гаргах гэж байгаа юм. Энэтэй холбоотойгоор тэр үр дүнгийн урамшууллыг жилд 80 хувиар олгодог байх санал гаргах гэж байгаа. Дээд шүүх бол 120 хувь байсан байх. 160 хувиар үр дүнгийн урамшууллыг нь олгох санал ирүүлсэн. Энийг нь 80 хувиар 2 дахин бууруулахаар санал гаргая гэсэн ийм саналтай байгаа.

Хоёрдугаарт бараа үйлчилгээний бусад зардал дээр албан хаагчдыг гадаад хэл, Монгол бичгийн сургалтад хамруулах дээр 207.8 сая, мэргэшүүлэх сургалт дээр 72 сая төгрөг төсөвлөсөн байгаа юм. Энэний нийт 280 сая төгрөгийг нь хасъя гэсэн ийм санал гаргах гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо би гаргаж байгаа юм. Тийм, ийм санал гаргах гэж байгаа юм, гаргаж байгаа юм.

Ингээд энэ гаргаж байгаа саналтай холбоотойгоор Ганбат гишүүн асуулт асууя гэж байна.

Д.Ганбат: Үгүй ээ бид нарын амьдрал ахуй ямар байгаа билээ. Тэгээд энэ шагнал, урамшууллаа больсон нь дээр байх. Бүгдийг нь хассан нь дээр байх. Их сайн ажиллаад байгаа юм харагдахгүй байна. Тийм, нөгөө талаар энэ наад Улсын дээд шүүхийн наад төсвийг захиран зарцуулдаг хүн нь ямар хүн байна. Хэн зарцуулдаг юм бэ. Тэгээд өмнөх яг мэдэж зарцуулдаг хүн нь байна уу. Гар хөлийн үсэг зурдаг хэдэн хүн, уул нь захирал, нягтлан гээд л зурдаг л даа. Энэ улсууд нь яаж зурдаг юм. Хэний заавар, чиглэлээр зурдаг юм.

Нөгөө талаар өмнөх эд нарт аудит орсон юм байна уу. Яагаад гэнэтхэн ингээд шагнал, урамшуулал, судлаач энэ тэрийг нэмье барья гээд явчхав. Энэний цаана Улсын дээд шүүхийг бас худалдаж авдаг тохироо энэ бас янз бүрийн наймаанд оролцсон энэ юмыг тэгээд бас татвар төлөгчдийн мөнгөөр ингэж төлбөр хийж байгаа ийм юм байна уу, үгүй юү. Тийм, аан. Тэгээд өнөөдөр аан

үгүй яах вэ тэгээд нэг их мөнгө оруулж ирээд тэрийг нь талыг нь хасаж байна гээд ер нь 1 төгрөг ч 1 төгрөгтөх үгүй шүү дээ.

Тэгээд энэ юмнуудаа бүгдийг нь хасъя гэсэн бодолтой байна. Эхлээд тэр аудитыг нь оруулъя, тэр захиран зарцуулдаг. Би энэ хоёр, гурван эмэгтэйг гар хөлийн үсэг зарцуулаад бүгдийг нь мэдээд идэж уугаад байна гэж бодохгүй байна. Цаана нь бол нэлээн хуйвалдаан явж байна уу гэж ойлгоод байна. Тэгээд л одоохондоо тийм судлаачид шаардлагатай байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Эхлээд байгаа нөөц бололцоо дээрээ аятайхан шиг ажиллаад, наад нэр хүнд юм хумаа өргөж бариад, тэр ард түмний энэ хүсэл, зорилгод нийцсэн тэр өмнөхөө хуулиа биелүүлж бариад ингэж ажилласан нь дээр байгаа. Хүний эрх бол шалан дээр байгаа шүү дээ ерөөсөө. Тэр Монгол Улсын Үндсэн хуулиар хангагдах ёстой.

Яагаад шалан дээр байна вэ гэхээр хууль биелүүлдэггүй Улсын дээд шүүх тэрний баталгаа нь болж зогсож чаддаггүй энэнээс болж байна л гэж би үзээд байгаа шүү дээ. Тэгээд энэ мөнгө, өмнө аудит орж байсан юм уу, тэр аудитын тайлан байна уу. Ер нь оруулах ёстой юм уу, оруулах ёсгүй юм уу.

Б.Энхбаяр: 2022 оны төсвийн гүйцэтгэл ирэх 7 хоногт Байнгын хороогоор орно. Тэгэхээр Ганбат гишүүний яг асууж байгаа Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрэн дэх бүх байгууллагын ирэх оны төсвийн гүйцэтгэл түүнд хийсэн аудитын дүн шинжилгээтэй холбоотой асуудал ирэх долоо хоногийн Байнгын хорооны хуралдаанаар орно. Тэр үед та бас бүх албан тушаалтнуудаас нь дэлгэрэнгүй мэдээлэл авах ийм боломжтой байгаа.

Одоо саяын ярьсан зарчмаар санал хураая. Сангийн яам маань бас төсвийн хязгаар тавьсан байгаа. Бид нар төсвийн хязгаарт бас нийцүүлж төсвийг бас гаргах учиртай. Байгууллагуудаас

ирүүлсэн саналыг 100 хувь ингээд бүгдийг нь дэмжээд яваад байвал энэ бас боломж байхгүй гэдгийг бас манай Байнгын хорооны гишүүд маань ойлгож байгаа байх.

Тийм учраас саяын хэлсэн, миний гаргасан зарчмыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ганбат гишүүн горимын санал гаргая. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Уг нь тийм. Шүүх, ерөнхий зөвлөл, Дээд шүүх, Сахилгын хороо гээд энэ хэдэн шүүхийн байгууллага чинь Их Хурал, Байнгын хороогоор төсвөө хэлэлцүүлнэ гэдэг нь Сангийн яаман дээр л бага хэрчээсэй л гэж бодож байгаа юм уу. Хүний эрхийн комисс байна бас. Тэгээд тэнд очихоор дахиад хасдаг, энд бас бид нар ингээд хасдаг. Энэ байгууллагууд өнөөдөр энэ шүүхүүд явуулж байгаа энэ хурлын заалнуудыг хар л даа очоод. Тэр төрийн сүлдээ өргөчихсөн байгаа юм. Хамаагүй хамаагүй энэ ер нь шүүх л бол шүүх тэгээд л том мөнгөөрөө л явна шүү дээ. Үүнээс чинь эхлээд л хэрэг зөв шийдэгдэхгүй байна, буруу шийдэгдэхгүй байна. Шүүхэд хандах иргэдийн итгэл, хандлага, итгэл үнэмшил чинь тэр танхимд ороод л гарч ирж байгаа шүү дээ. Хоёрын хооронд 200 сая төгрөг, 300 сая төгрөг гээд ямар том бодлогын яг Дээд шүүхийнхээ шүүгчдийн нийт орон тоог энэ Тамгын газрынхаа орон тоог 100 хувь нэмье гэж байгаа биш. 20, 30-хан хүний асуудал дээр бид нар энд тийм жижиг юм яриад байхав.

Тэртээ тэргүй энэ Сангийн яаман дээр очоод дахиад хасуулна. Тэгээд Сангийн яам яагаад Сангийн яам яагаад Сангийн яаман дээрээ яаж хасуулахгүй байх вэ гэдгээ тэр хуулиа нэг мөр хэрэгжүүлэх юмаа л бид нар бодох ёстой. Энэ хүмүүст өнөөдөр зарцуулаад яваад байгаа хэдэн ном, сурах бичиг, судалгааны л мөнгө байгаа байх. Энэ байтугай төсвийн юм л зөндөө л явж байдаг энд. Энэний араас энэ Хүний

эрхийн комисс дахиад орж ирж байна. Дахиад л бас жаал багасгасан, тансан л юмнууд орж ирнэ. Тэгээд бид нар хүний эрх ярина, шүүх шударга байх тухай юм ярина. Энэ аягүй их л утгагүй л юм байгаа юм.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн горимын санал гаргая. Горимын санал дэмжигдсэнгүй.

Дараагийн төсөв үү, санал хураалт уу. Санал хураалт чинь, санал хураалт энэ чинь байхгүй байна шүү дээ. Саяын санал чинь дэмжигдсэнгүй шүү дээ. Ерөөсөө яасангүй шүү дээ.

Улсын дээд шүүхийн 24 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа.

Одоо Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн төслийн талаар хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Онончимэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Батрагчаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Наранбилиг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг гүйцэтгэгч нар оролцож байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Онончимэг танилцуулна. 2 номерын микрофон.

Р.Онончимэг: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Шүүхийн ерөнхий зөвлөл нийт 2024 оны төсвийн саналыг 204.5 тэрбум төгрөгөөр оруулж ирсэн. Үүнээс урсгал зардалд 131 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 72 тэрбумыг оруулж ирсэн. Энийг нэг бүрчлэн задаргааг нь танилцуулах уу тээ.

Бараа, үйлчилгээний зардалд 120 тэрбум, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 85.9 тэрбум, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл нь 10.7 тэрбум, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4.2 тэрбум, хангамж, бараа материалын зардал 5.3 тэрбум, норматив зардалд 112 сая 800, эд хогшил, урсгал засварын зардалд 8.3 тэрбум, томилолтын зардалд 900 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 3.2 тэрбум, бараа, ажил үйлчилгээний бусад зардалд 1.2 тэрбум, урсгал шилжүүлэгт 11.6 тэрбум төгрөг байхаар.

72 тэрбум төгрөгийн задаргааг нэгдүгээрт барилга, байгууламж 63.1 тэрбум, тоног төхөөрөмжийн зардалд 8.5 тэрбум, их засварт 1 тэрбум байгаа. Барилга байгууламжийн зардлын задаргаа Улаанбаатар Хан-Уул дүүрэгт баригдах барилга, шүүхийн барилгын нийт 75 сая тэрбум төгрөгийн 1/3 зардал орж ирсэн 25 тэрбум төгрөгөөр. Завхан аймгийн Улиастай сум дахь шүүхийн барилгын зардал 12 тэрбум төгрөгөөр, Улаанбаатар-Налайх дүүргийн өргөтгөлийн барилга 1.5 тэрбум төгрөгөөр, Дундговь аймгийн төвийн шүүхийн барилга өргөтгөл 669 аравны 800 мянган төгрөгөөр ингэж орж ирсэн.

Тоног төхөөрөмжийн зардал дээр нийт шүүх хуралдааны танхимд дуу, дүрсний бичлэг хийх, архивлах төхөөрөмж 2 тэрбум төгрөг байхаар, анхан болон давж заалдах шатын шүүхийн шүүгч нарт зөөврийн компьютер 2 тэрбум төгрөг байхаар, орон нутгийн 31 шүүхийн тамгын газарт автомашин 4.5 тэрбум төгрөг байхаар орж ирсэн. Их засварын зардал маань захиргааны хэргийн анхан шатын шүүхийн фасадын засвар гээд 800 сая төгрөг, Баянхонгор болон Өвөрхангай аймгийн шүүхийн халаалтын шугам шинэчлэх зардал 200 сая төгрөг байхаар танилцуулагдаж байна.

Б.Энхбаяр: Баярлалаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээний газраас хийсэн санал, дүгнэлтийг гишүүдэд тарааж танилцуулсан байгаа.

Танилцуулгатай холбоотойгоор асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Ингээд уул нь Улсын дээд шүүхийг ер нь шүүх үйл ажиллагаагаа шүүхэд л би ямар нэгэн мөнгө төгрөгтэй холбогдолгүйгээр л бие дааж явуулаг гээд л. Энэ асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл маань дангаараа хариуцаж байгаа юу, ямар байгаа юм та бүхэн. Би гүйцээгээд асуучихъя. Шүүгчийг сонгон шалгаруулахаас гадна шүүхийг хэвийн үйл ажиллагаа явуулах тэр төсөв, мөнгөний асуудал та нар дээр байгаад судалгаа, шинжилгээ, хурал энэ бүх юм Шүүхийн ерөнхий зөвлөл дээр л явуулж байх ёстой гэж би ойлгоод байгаа шүү дээ.

Тэгтэл сая та нарын өмнө Улсын дээд шүүхээс судлаачтай байя, тэр хурал, цуглаан, сургалтыг бас тэн дээр явуулъя гэсэн ийм саналууд орж ирж байна. Ингээд энэ үйл ажиллагаа чинь давхардаад байна уу ямар байна. Хамгийн орхигдоод байгаа хэсэг энэ дээр анхаарахгүй байгаа энэ зүйл бол энэ шүүн таслах үйл ажиллагаа. Анхан шатын шүүгч нар чинь хэвийн үйл ажиллагаа явуулж тэр хараат бус шүүх үйл ажиллагаа явуулах ийм боломж нь байна уу, хангагдаж чадаж байгаа юу. Байшин барилгын хувьд шаардлага хангахгүй ийм байшин барилгатай гэдгийг ойлгож байна. Тэрийг чинь дэмжиж байна.

Ер нь шүүхийг хараат бус үйл ажиллагаа явуулах төсөв, мөнгөний хувьд яг тэр хуульд заагдсан энэ хэмжээнд байлгахын төлөө байдаг хүний нэг бий гэж ойлгодог. Шүүх одоо яг шаардлагатай үйл ажиллагаа, яг тэр

юмаа явуулж чадахгүйгээс болоод энэ олон ард түмний дунд нэр хүнд нь уначихсан, шударга, ёсыг тогтоох, хүний эрхийг хамгаалах энэ бүх юм чинь хамгийн сүүлийн байранд л шахуу явж байна шүү дээ. Дэлхий нийтийн хэмжээнд гэж ойлгож байна. Энэ хэд хэдэн үйл ажиллагаагаар харагдаж байна.

Тэгээд та хэд маань Шүүхийн ерөнхий зөвлөл одоо бас яг тэр шүүхийнхээ төлөө, шүүгч нарынхаа төлөө хараат бус үйл ажиллагаа явуулж чадаж байна уу. Яг ямар байгаа юм. Төсөв мөнгө нь хүрэлцээтэй байгаа юу. Тэгс ингэс хийгээд дуусаж байна уу. Наад юман дотор чинь тэр анхан шатын шүүгч нарын хэвийн үйл ажиллагаа явуулах ийм зардал чирэгдэл байна уу.

Үүнээс гадна төсөв мөнгө хэмнэх аягүй их боломжууд байдаг. Тухайлбал шүүгч нарын ачаалал, шүүхийн ачаалал олон газар харилцан адилгүй байна. Ийм учраас тойргоор шүүх байгуулах ийм боломжууд гараад ирчихсэн байгаа. Энэ юм хумаа хэзээ хийх юм бэ. Энийгээ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асуудлыг оруулж ирэх гэж байна уу, энэ Засгийн газар нь оруулж ирэх гэж байна уу, энэ Хууль зүйн байнгын хороон дээр яригдаж байна уу, ямар шатад явна гэдгийг би лавламаар байна.

Яагаад гэвэл би сөрөг хүчин гэдэг юм уу, цөөнхийн төлөөллийн хувьд ингээд орхигдоод яваад. Тэгээд тэгс ингэс хийгээд асуудлууд яваад байна. Энэ мөнгө төгрөг зөв зүйтэй, шаардлагатай зүйлд зарцуулагдахгүй иймэрхүү маягтай явж байна. Энэний улмаас шүүхийн хараат бус үйл ажиллагаа явуулах, шүүн таслах үйл ажиллагаа яг одоо тэр ард түмнээс, нийгмээс, нийтээс тэр хуулийн дагуу шаардаад байгаа тэр хэмжээнд очихгүй байна. Маш удаан ийм байдалтай байна. Энэ ямар учиртай юм бэ гэдэг зүйлийг бас асууя.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Өчигдөр бол Төсвийн

байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооноос хамтарсан ажлын хэсэг гараад тодорхой дүүргүүдийн шүүхийн үйл ажиллагаа, байрны нөхцөлтэй танилцсан. Мөн үүний өмнө Төсвийн байнгын хорооноос Шүүхийн зөвлөл дээр ажиллаж энэ ирэх оны төсөв, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудаар бас тодорхой хэлэлцүүлгүүдийг хийж, хамтран ажиллаж энэ жишиг дээр бас бодлогуудаа нэгтгэсэн гэж ойлгож байгаа.

Ингээд Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүх хэргийн зөвлөлийн дарга Онончимэг асуултад хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье.

Р.Онончимэг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхийн тухай хуульд Улсын дээд шүүхээс бусад төсвийг анхан болон давж заалдах шатын шүүхийн төсвийг Ерөнхий зөвлөл оруулж ирэхээр байгаа. Тэгэхээр хуульдаа Улсын дээд шүүхээс бусад төсөв гэсэн учраас Ерөнхий зөвлөл энэ талаар Улсын дээд шүүхийн төсвийн талаар ярих боломжгүй. Анхан болон давж заалдах шатын шүүхийн төсвийн асуудал бидэнд хамаатай байгаа. Мөн Улсын дээд шүүхэд 2021 онд батлагдсан хуулиар шүүгчийн сургалт, судалгааны ажил Улсын дээд шүүхийн дэргэдэх хүрээлэнд хамаарагдаж байгаа. Энэ хүрээндээ сая Улсын дээд шүүхийн төсөвт нэгтгэгдэж танилцуулагдсан байх гэж бодож байна.

Хоёрдугаарт гишүүн шүүгчийн хараат бус байдал анхан шатын шүүхүүдийн хараат бус байдлын талаар бас асуулаа. “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг болон хараат бус иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг төлөвшүүлнэ гээд. Энэ хүрээнд 2021 оны хууль батлагдсан гэж бид нар ойлгож, хэрэгжүүлж явж байна. Энэ дээр илүү шүүх ил тод, нээлттэй байх, мөн шүүхийн үйл ажиллагааг цахимжилтаар дэмжих ийм зохицуулалтууд орж ирсэн.

Сүүлийн арваад жилийн байдлаар хөрөнгө оруулалтын төсөв бол харьцангуй шүүх дээр тавигдаагүй. Тэгэхээр мөн шүүгчийн цалингийн асуудал 2013 оноос хойш бодитой нэмэгдэл байхгүй, дунджаар 3 сая төгрөгийн цалинтай ажиллаж байна. Байр, ахуйн хангамж, ялангуяа нийслэлийн 6 дүүргийн хувьд шүүгчийн ачаалал маш их өндөр байгаагаас болоод шүүхийн үйлчилгээ бас иргэдэд маань тодорхой хэмжээнд хүрч чадахгүй ийм нөхцөлүүдийг үүсгэж байна.

Шүүх байгуулах тухай хуультай холбоотойгоор саналуудаа боловсруулаад Улсын дээд шүүхтэй зөвшилцөд Засгийн газарт ирчихсэн байж байгаа. Тэгэхээр Засгийн газар маань намрын чуулганд оруулах болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл хаврын чуулган хаагдах гэж байгаа учраас. Энэ дээр шүүхийг тойргийн журмаар байгуулах, мөн бага үнийн дүнтэй маргаануудыг шийдвэрлэх, зөрчлийн хэргүүдээ тусад нь шийдвэрлэх эд нар гэсэн ийм шүүхүүдийн саналуудыг шүүх байгуулах саналуудыг бас оруулж ирсэн явж байгаа.

Энэтэй уялдуулаад шүүхийн байр, байшин мөн бусад цахимжилтын зардлуудын танилцуулгуудыг оруулж ирсэн. Мөн Шүүхийн тухай хуулийн 5.11-д шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлоготой байх талаарх ийм зохицуулалтыг хийсэн. Энэ талаарх саналаа боловсруулаад Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн байгаа. Мөн яг одоо Засгийн газар дээр зөвшилцөх шат явж байна. Энэ дээр мөн шүүхийн үйл ажиллагааг нээлттэй болгох, иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг дэмжих, шударга шүүхээр шүүлгэх, иргэний эрхийг, баталгааг хангах энэ чиглэл рүү дандаа төсөв, санхүүг нь тавьж өгсөн явж байгаа.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Юу, үгүй ээ энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн энэ

байгууллагуудад тэр Засгийн газрын тэр Алсын хараа ямар хамаатай юм бэ. Тийм, тэр гүйцэтгэх засаглал чинь тусдаа шүү дээ. Тэр гүйцэтгэх засаглалынхаа юмыг хийж хэрэгжүүлдэг тийм дагавар байгуулах шиг л ийм ойлголттой байна уу, үгүй юу. Тэгж болохгүй.

Тэгээд наад анхан шатын шүүх нь өөр, давж заалдах шатын 2 шүүх нь ингээд танайд харьяалгагдаад хөрөнгө мөнгөө шийдүүлээд явдаг. Улсын дээд шүүх нь болохоор тусдаа байдаг гэдэг чинь тэгээд бас л энэ чинь нөгөө бүх юм адилхан байх ийм зарчим нь алдагдаад байна шүү дээ. Алдагдаж байна гэж би ойлгож. Тэр юмыг хутгаад ингээд байх шаардлагагүй л ийм л зүйл байна гэж би ойлгоод байна Энэ дээр ямар санал, бодолтой байна вэ.

Б.Энхбаяр: Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Энийг шүүх хуралдааны танхимууд чинь шаардлага хангахгүй хэдэн газар байна. Дүүрэг, нийслэл. Шаардлага хангахгүй шүүх хуралдааны танхимууд чинь. Тэрний чинь яг төсвүүд нь энэ дотроо бүрэн суусан уу. Шаардлага хангахуйц болгох хэмжээнд. Энэ төсөв дээр чинь яг тэр нь орж ирсэн үү.

Б.Энхбаяр: Онончимэг дарга хариулъя. 2 номерын микрофон.

Р.Онончимэг: Гишүүний асуултад хариулъя. Улсын хэмжээнд 116 шүүхэд 129 шүүх хуралдааны танхим байна. Нийслэлийн хэмжээнд шүүх хуралдааны танхимууд маань шаардлага хангагдахгүй байгаа. Энэ талаарх урсгал зардлын төсвүүдийг тавьж өгсөн байгаа. 4.5 тэрбумаар тавьж өгсөн байгаа. Тэгэхээр 2024 онд засварууд хийгдэх боломжтой. Барилга, байшингийн асуудал бол хөрөнгө оруулалт дээр тусдаа тавигдаж өгсөн. Суусан байгаа. Засварын зардлууд орж ирсэн байгаа.

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Өчигдөр Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо хамтарсан гишүүд энэ Хан-Уул, Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатын шүүхийн үйл ажиллагаатай танилцсан газар дээр нь. Шүүгч нар ер нь ямар өрөө, тасалгаанд үйл ажиллагаагаа явуулж байна, шүүхийн туслахууд, мөн архив, бичиг хэргийн ажилтнууд, шүүхийн ер нь архив, бичиг хэрэг ямар орчин нөхцөлд, ямар шаардлага хангасан архивд хадгалагдаж байна, шүүх хуралдаанууд ер нь ямар орчинд явагдаж байна, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа түүний орчин нөхцөл ямар байна, иргэдийн өргөдлийг хүлээж авч байгаа тэр мэдээлэл өгөх, лавлагаа авах энэ орчин нөхцөл ямар байна, одоогоос 10 жилийн өмнө шав нь тавигдсан Хан-Уул дүүрэгт байгаа 3 дүүргийн цогцолбор барилгын ажлын явцтай бас танилцсан гээд.

Ер нь бид нар бас мэддэггүй л юм байна лээ л дээ. Шүүх, шүүхтэй холбоотой төсөв санхүү ярихаар шүүгч нар хамгийн өндөр цалин авдаг, шүүгч нарын цалинг нэмэх гээд байгаа юм шиг юм ойлгож явж байсан юм байна. Миний хувьд лав. Шүүхтэй төдийлөн холбогддоггүй байсан учраас орчин нөхцөлийг, үйл ажиллагаа ямар хэмжээнд явж байгааг ерөөсөө мэддэггүй юм. Шүүгч нар эрүүгийн хэргийн асуудлаар л хараад байдаг. Гэтэл энэ чинь ерөөсөө захиргааны, иргэний хэргийн асуудал гээд ингээд маш олон төрийн үйлчилгээг бид нар ерөөсөө энэ орхигдуулж ирсэн байгаа юм байна гэдэг нь харагдсан.

Ер нь нийт дүнгээрээ ингээд 3 хүн тутмын бараг 1 нь буюу жилд дунджаар бараг 1 сая орчим хүн энэ бүх шатын шүүхээр үйлчилгээ авсан ямар нэг байдлаар хамрагдсан байх ийм тоо судалгаа байдаг юм байна л даа. Үгүй ингэхээр энэ чинь ер нь энэ шүүхийн тэр

дундаа иргэн, захиргааны хэргийн шүүх чинь ер нь ямар их ачаалалтай байдаг юм. 1 шүүгчид дунджаар Хан-Уул дүүргийн шүүгч дунджаар 209 орчим хэрэг байх ёстой боловч Хан-Уул дүүргийн шүүгч 800 гаруй шүүх хэрэг дээр ажилласан. 3.6 дахин ийм ачаалалтай ажилласан гэсэн ийм тоо юмтай л ярьж л байна лээ л дээ.

Тэгээд шүүх хуралдаан үндсэндээ ямар орчинд явагдаж байна гэхээр үнэхээр өрөвдөлтэй. 14 онд актлагдчихсан үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн ийм байранд л өнөөдрийг хүртэл бараг 10 орчим жил үйл ажиллагаа явуулж байх жишээтэй. Үнэр танар гээж тэнд авахын юм алга, тохижилт гээж юм авахын юм алга, орчин нөхцөлд тэр стандарт юм тэнд ярихын утга учир бол үнэхээр байхгүй болсон юм байна. 10 хүрэхгүй метр квадрат талбайд бөгс эргэх зайгүй талбайд шүүгч суугаад өөдөөсөө хэргийн оролцогчийг суулгаад бараг гарын үсэг юу юун дээр тэмдэглэж байгаа нь өөд өөдөөсөө бие биеэ хараад, харагдахаар бараг амьсгалж байгаа нь мэдэгдэхээр ийм л орчин нөхцөлд манай иргэний хэргийн шүүхийн үйл ажиллагаанууд явагдаж байна.

Тэгэхээр эндээс үйлчилгээ авч байгаа иргэд ер нь шүүхийн талаар, цаашилаад төрийн үйлчилгээний талаар ер нь ямар сэтгэл ханамжтай, яаж гарах нь гэдэг нь ойлгомжтой юм байна лээ.

Тийм учраас бид нар тэгээд ингээд харахаар ер нь өнгөрсөн бараг 20 жилийн хугацаанд шүүхийн салбарт улсын төсвөөс хөрөнгө оруулалт байхгүй явж ирсэн юм байна. Нойл. Энийг ингээд бодохоор нээрээ үнэхээр бас янз бүрийн л улс төрийн шалтаг, шалтгаанууд байсан юм шиг байгаа юм. Тэгээд энэ чинь ингээд 20 жил гэдэг бол хөрөнгө оруулалт нойл байна гэдэг үнэхээр бас энэ салбарынхан бид нар эмнэлэг, сургууль, цэцэрлэг гээж ярьсаар байгаад энэ салбарынхныг үнэхээр энэний цаана

төрийн үйлчилгээ иргэнд хүрч байгаа гэдэг энэ утгаар ерөөсөө байхгүй болсон юм байна шүү.

Тийм учраас бас энэ Их Хурлын гишүүд ер нь бас. Шүүгч нар ярьж байна лээ 7 жил.../минут дуусав./

Б.Энхбаяр: Тодруулж асууя Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Маш олон шүүгч нартай уулзаж санал хүсэлтийг нь сонссон. 7 орчим жил, 10 гаруй жил ажиллахад ер нь ингэж Их Хурлын гишүүд шүүх, шүүхийн байраар шүүгч нартай уулзаж байсан тохиолдолд би мэдэхгүй байна. Анх удаа ирж байна гэдэг юмнуудыг олон шүүгч нар ярьж байна лээ.

Тийм учраас Их Хурлын гишүүд магадгүй нөгөө хуулиараа бас тэр болгон шууд уулзах хориотой л доо. Гэхдээ ийм ажлын чиглэлээр, хуулийн чиглэлээр эд нар ингээд уулзах асуудлууд ерөнхийдөө байдаггүй л юм байна л даа. Тийм учраас энэ шүүх, шүүхийг харах энэ хандлага юмаа бас хууль тогтоогч нар, эрх баригч нар бас арай өөрөөр харах ёстой юм байна лээ. Үүний цаана төрийн үйлчилгээ яваа юм байна гэдгийг бас бодох ёстой юм байна лээ шүү гэдгийг бас нэгт хэлье.

Тийм учраас би энэ оруулж ирсэн төсөв, хөрөнгө юмыг бол бас дэмжиж байна гэдгээ бас хэлчихье.

Хоёрт бол Багануур дүүрэг бол энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн өмнөх бүрэлдэхүүний үед ч гэсэн өөрийн гэсэн байргүй яваа дүүргийн нэг. Судалгаанд бол олон жил яваа. Та бүхэн танилцуулга дээрээ болохоор байгаа гэсэн боловч яг хөрөнгө мөнгө дээр.../минут дуусав./

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн төсөлтэй

холбоотойгоор үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна. Би үг хэлье.

Сая өчигдөр Төсвийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны гишүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 24 оны төсвийн төсөл хэлэлцэх гэж байгаатай холбоотойгоор Нийслэлийн Хан-Уул, Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатын шүүхийн үйл ажиллагаа, нөхцөлтэй танилцсан.

Хан-Уул дүүрэг дээр биднийг очиж үзэхэд ердийн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан норматив ачааллаас 1 шүүгчид ноогдох гэж байгаа ачаалал 3.6 дахин их байсан. Баянзүрх дүүргийн тухайд 2 дахин их, 24 оны гүйцэтгэлээр өнгөрсөн оныхоосоо 2 дахин их бүүр 1 жилийн дотор хэрэг, маргаан шийдвэрлэх ийм нөхцөл байдалтай. Шүүх бол нэг талаасаа үйлчилгээний байгууллага байдаг. Тэнд маш олон мянган иргэн үйлчлүүлж байгаа. Зөвхөн Баянзүрх дүүрэг дээр гэхэд өнгөрсөн онд иргэний шүүх шүү, энэ иргэний шүүхийг яриад байгаа юм. 5200 хэрэг маргааныг 10 гаруй шүүгч шийдсэн. 1 шүүгч ер нь дунджаар дөрөв, таван зуун хэрэг шийдсэн.

Хан-Уул дүүргийн шүүх одоо 8 шүүгч ажиллаж байгаа. Орон тоо дутуу. Шүүхийн ерөнхий зөвлөл хамгийн өндөр ачаалалтай ажиллаж байгаа энэ Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн шүүхүүд дээр шүүгчийн орон тоо зарлаад хүн бүртгүүлэхгүй байна гэж байгаа бүүр. Шүүгчийн орон тоон дээр хүн бүртгүүлэхээ больсон байна. Одоо бүтэн жил болж байна гэж байна. Энэ юу хэлээд байна вэ гэхээр маш өндөр ачаалалтай тэгээд 2.7 сая төгрөгийн цалинтай, цаг нар байхгүй.

Тэгээд ийм өндөр ачаалал дээр ер хуульчид ажиллая ч гэж ер нь өрсөлдөхөө больчихсон юм байна. Ер нь яг ийм байдлаар 1, 2 жил явбал одоо ажиллаж байгаа шүүгч нар нь энэ өндөр ажлын ачааллаасаа хамаараад ер нь больё гэдэг ийм байдал руу орох, байдал руу орчихсон

байна. Бодитой. Өчигдөр энэ Байнгын хорооны гишүүд бас энэ шүүхүүдтэй танилцаж явахад энэ нөхцөл байдал бас гарч ирсэн.

Тийм учраас энэ Шүүхийн ерөнхий зөвлөл оруулж ирсэн төсөл нь бол одоо Шүүхийн ерөнхий зөвлөлөөр хэлэлцээд сая бас Улсын дээд шүүхээс саналыг нь авчихсан байгаа, удахгүй Засгийн газраас өргөн барих гэж байгаа Шүүх байгуулах тухай хуулийнхаа концепцтой нийцүүлж 24 оныхоо төсвийн төслийг бас оруулж ирсэн байна лээ.

Мэдээж нэмэгдэж байгаа дүн нь их өндөр харагдаж байгаа юм шиг болов чиг, сүүлийн 8 жилийн хугацаанд шүүхэд хөрөнгө оруулалтын төсөв ерөөсөө баталж өгөөгүй. 0 дүнтэй баталчихсан. Хамгийн сүүлд 10 жилийн өмнө аймгуудын шүүхүүдэд нэг нэг автомашин авч өгсөн юм байна лээ. Хамгийн сүүлд жишиээлбэл.

Одоо бидний энэ хотын төв яг ордны хойно байгаа Сүхбаатар, Баянгол, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатын шүүх коридорт өрөө гаргаад шүүх хурлаа хийж байна. Шүүх хурлынхаа бүүр коридорт нь. Ийм байдалтай байна. Ер нь нөхцөл байдал. Хэргийн оролцогч шүүгчтэйгээ өөд өөдөөсөө хараад өрөө байхгүй, шүүх хурал нь ерөөсөө ийм өөд өөдөөсөө хараад ийм жижигхэн яг хэдэн метр квадрат юм бэ тийм ээ Сандаг-Очир гишүүнээ. Бид нар очиход 6 метр квадрат юм уу тэр бараг 10 хүрэхгүй тийм өрөөнд шүүх хурал хийж байна. Ерөөсөө коридорт.

Нөгөө хэргийн оролцогчид орох байтугай ерөөсөө тэр 1 хүн суугаад шүүгч нь өөдөөс нь яг нүүр нүүрээ харж суугаад тэгээд хэргийн оролцогчдод шүүгчийнх нь урд нь байгаа хэрэг нь харагдаж байдаг. Тэгээд та ингэчихсэн байна шүү дээ гээд ярьж байна гэж байгаа юм. Бүүр оролцогч нь шүүгчийнхээ юмыг хараад сууж байдаг. Бие биеэ. Та сая миний регистрийг буруу

бичихлээ шүү дээ гээд ингээд өөдөөс нь хараад сууж байна гэж байгаа юм. Тэгээд ийм нөхцөл байдалд Монгол Улсын шүүх хэрэг, маргаанаа тасалж байгаа ийм байдалтай.

Тэгээд сүүлийн үед гарч байгаа жишиээлбэл энэ том хэргүүдийг, олон оролцогчтой хэргүүдийг явуулах шүүх хуралдааны танхим байхгүй. Хөвсгөл аймагт Мөнхбаатар дарга мэдэж байгаа. Энэ Бэлтэсмөрөн гээд энэ маш олон мянган иргэдийг хохироосон ийм том хурлыг жишиээлбэл спорт зааландаа гуйж түүгээд түрээс тавиад ингээд шүүх хурлаа хийж байна гэж байгаа юм.

Сая Шүүхийн ерөнхий зөвлөл зохион байгуулаад энэ Хөгжлийн банкны 80 гаруй оролцогчтой шүүх хурлыг 2 сар хийсэн. Мөн ийм түрээсийн шугамаар гүйцэтгэлээр нь мөнгийг нь өгнө гэж хэлээд ингээд шүүх хурал хийж байх жишээтэй ийм асуудлууд гараад байгаа юм. Мөн энэ маш олон мянган оролцогчтой Жи Тайм билүү ийм сүлжээний оролцогчдын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг чинь бүх хүмүүст нь шүүхийн шийдвэрээ гардуулах ёстой. Тэгээд ийм 1000 гаруй ийм оролцогчтой хэргүүдийн шүүхийн шийдвэрийг зөвхөн гардуулж өгөх гэж байгаа хувилаад өгч байгаа зардал нь гэхэд 100 гаруй сая төгрөг болж байна гэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ зардлууд нь ерөөсөө байдаггүй. Үндсэндээ бол 10 жилийн турш ингээд ямар ч хөрөнгө оруулалт хийгдээгүй.

Тэгээд энэ асуудлыг бол яг төсвийн бодлоготой хамт өчигдөр бас Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэн дарга өөрөө бас яг ингээд биечилж танилцаад, энийг ер нь яаж шийдэх вэ иргэдийн энэ шударга шүүхээр ийм орчинд үйлчлүүлэх, энэ чинь үйлчилгээ аваад байгаа байхгүй юу. Төрийн үйлчилгээ авч байгаа шүү дээ. Энэ үйлчилгээг ер нь яаж энэ нөхцөл дээр нь анхаарах вэ гэдэг асуудлыг яриад 2024 оны энэ оруулж ирсэн зарчмын хувьд зардлаар нь дэмжье. Энэ бол бүх асуудал ерөөсөө шийдэж байгаа юм байхгүй

байгаа юм. 10 жилийн өмнө тэр шав тавьсан шүүхийн байр гээд 4 тэрбум төгрөг одоо шав тавьчихсан байгаа. Тэр Яармагт байгаа шүүхийн цогцолбор барилгыг ямар ч байсан эхлүүлье ерөөсөө, дуусгая. Газрын маргаан бүрэн цэгцлэгдсэн байна. Ямар ч асуудал байхгүй. Бид өчигдөр танилцаж үзсэн.

Энэ 2024 онд эхний ээлжид 25 тэрбум төгрөгийг нь суулгаж өгье. Энийг ялт ч байхгүй суулгахгүй бол болохгүй юм байна. Тэр шүүхийн байруудын засвартай холбоотой асуудлууд байна. Энэ Хан-Уул, Баянзүрх дүүргийн энэ дандаа иргэний шүүхүүд яриад байгаа юм. Энэ ачаалал ихтэй иргэний анхан шатын шүүхүүдэд шаардлагатай шүүгчийн орон тоог нь гүйцээе. Энэ нэгэнт шүүгчийн орон тоо авч байгаа учраас шүүгчийн туслах асуудлыг нь шийдье. Энэ дээр гол ачаалал аваад байгаа маш их нэмэгдээд байгаа хэрэг бол энэ иргэний шүүхүүд дээр байна. Ялангуяа нийслэл.

Энийг яаж бууруулах боломжтой вэ гэхээр ерөөсөө эвлэрүүлэн зуучлах энэ үйлчилгээг сайжруулъя. Тэгвэл энэ шүүхэд маргаад байгаа бага үнийн дүнтэй хэргүүд дээр бүх бүх юмаа шүүхээр шийдүүлнэ гэдэг энэ юм багасах юм байна. Засгийн газраас энэ Шүүх байгуулах тухай хуультай хамт эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг бага үнийн дүнтэй хэрэг дээр шийдвэрлэх хуулийн төсөл өргөн барих гэж байгаа юм байна. Энэ хуулийг нь Улсын Их Хурал яаралтай баталъя. Энэтэй холбоотойгоор эвлэрүүлэн зуучлагчдын орон тоог нийслэл Улаанбаатар хотын хувьд нэмье гэдэг ийм саналыг Ерөнхий зөвлөл гаргаж байгаа.

Энэ саналыг нь дэмжиж хүлээж авъя гэдэг ийм санал гаргаж байгаа. Ингээд орж ирсэн саналаас нь өчигдөр Байнгын хороон даргатай ярьж байгаад Байнгын хороон даргатай ярьж байгаад манай Тэмүүлэн гишүүн Архангай аймаг дахь шүүхийн барилгыг энэ төсөвт 24 оныг заавал төсөвт суулгахгүйгээр

шийдчих боломжтой юм гэдэг асуудлыг тавьсан.

Тийм учраас энийг нь хасаад шийдчихье. Тийм учраас би саналын томъёоллыг юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр Архангай аймаг дахь шүүхийн барилга Эрдэнэбулган төв сум 6 тэрбум 399 сая төгрөг гэдгийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураах гэж байгаа шүү. Энэтэй холбоотойгоор Завхан аймаг дахь шүүхийн барилга Улиастай төв 12 тэрбум 30 сая төгрөг гэдгийг 24 онд бүтнээр нь суулгая гэж байгааг төсөвт өртгийн 3 жил тэнцүү хуваагаад 2024 онд 4 тэрбум төгрөгийг нь санхүүжүүлэх ийм санал байгаа.

Тэгэхээр энийг бол саналын томъёоллыг нь Завхан аймаг дахь шүүхийн барилгыг 12 тэрбумыг нь 24 онд бүтнээр нь суулгая гэдэг саналын томъёоллоор би санал хураалгах гэж байна.

Мөн Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилгыг 12 тэрбум 801 сая төгрөгийг шинээр барихыг 2024 онд бүтнээр нь суулгая гэдэг саналын томъёолол оруулж ирсэн. Хянаж үзээд энийг бол төсөвт өртгийг нь 3 жил тэнцүү хуваагаад 24 онд 4.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлж гэдэг саналтай байгаа.

Тийм учраас саналын томъёоллыг нь Дархан-Уул аймгийн шүүхийн барилгыг 24 онд 12 тэрбум 801 сая төгрөгөөр бүтнээр нь суулгая гэдэг саналын томъёоллоор санал хураалгах гэж байгаа юм. Энэ саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 10 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дэмжигдээгүй учраас Архангай аймаг дахь шүүхийн барилга 6 тэрбум 399 сая төгрөгийг хасахаар, Дархан-Уул аймаг дахь шүүхийн барилга 12 тэрбум 801 сая төгрөгийг 3, төсвийн өртгийг 3

жил тэнцүү хувааж 2024 онд 4.3 тэрбум төгрөг болгож санхүүжүүлэхээр, Завхан аймаг дахь шүүхийн барилга Улиастай төв 12 тэрбум төгрөгийг төсөвт өртгийг 3 жил тэнцүү хувааж 2024 онд 4.1 тэрбум төгрөг болгож санхүүжүүлэхээр санал босож байна.

Сандаг-Очир гишүүний санал байгаа тийм ээ. Сандаг-Очир гишүүний санал байна.

Хөрөнгө оруулалт дээр Багануур дүүргийн шүүхийн барилга төсөвт өртөг 6.3 тэрбум төгрөг, 2024 онд санхүүжих нь 2 тэрбумыг дэмжье гэдгээр санал хураалт явуулах нь. Айн нээрээ тийм шүү дээ.

40 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй шүү.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны төсвийн төсөлтэй холбоотой санал хурааж дууслаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 24 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Одоо Шүүхийн сахилгын хорооны 2024 оны төсвийн төслийн талаар хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Шүүхийн сахилгын хорооноос Хашибаатар Шүүхийн сахилгын хорооны дарга, Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга, Ариунжаргал Шүүхийн сахилгын хорооны Ерөнхий нягтлан нар оролцож байна.

Шүүхийн сахилгын хорооны 2024 оны төсвийн төслийг Шүүхийн сахилгын хорооны дарга Хашибаатар дарга танилцуулна. 2 номерын микрофонд урьж байна. 2 номерт суучхаарай Хашибаатар дарга дунд талын суудалд. 2 номерын микрофоныг өгье. Хашибаатар дарга 2 номерыг өгөөрэй.

Х.Хашибаатар: Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, гишүүдийн амар амгаланг айлтгая энэ өдрийн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.1, 95.2 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн сахилгын хороо шинээр байгуулагдаад 2021 оны 11 сарын 18-ны өдрөөс бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн сахилгын хороо 2022 оны жилийн эцсийн байдлаар шүүгч нартай холбогдсон 462 өргөдөл хүлээж аваад, үүнээс 201-д нь сахилгын хэрэг үүсгэж, 245 хэрэг сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн байна. Энэ хугацаанд шийдвэрлэх шатдаа 16 өргөдөл хүлээгдэж байна.

Шүүхийн сахилгын хорооны даргын 2024 оны төсвийн төсөөллийг Төсвийн тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хуулийг тус тус үндэслэн нийт 4.1 тэрбум төгрөгөөр тооцоолж, урсгал болон хөрөнгө оруу оролтын зардлын төсвийн төсөөллийг боловсрууллаа.

Үүнээс урсгал зардлын төсвийг 3.8, хөрөнгө оруулалтын төсвийг 300 сая төгрөгөөр тооцсон болно. Урсгал зардлыг задалж харьцуулбал цалин хөлс, нийгмийн даатгалын зардал 2.5 тэрбум төгрөг, бараа, бусад үйлчилгээний зардал 1.3 тэрбум төгрөг байна.

Цаашид Улсын хэмжээнд шүүгчийн сахилга, зөрчилтэй холбоотой өргөдөл, мэдээллийг хүлээн авч өргөдөл, гомдол, мэдээлэл сахилгын хэргийг хуулийн хугацаанд шийдвэрлэснээр шүүгчийн ёс зүй сахилга хариуцлага дээшлүүлэх гол зорилгодоо хүрч ажиллах болно.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.21 дэх хэсэгт зааснаар Сахилгын хорооны төсвийг боловсруулж батлахад энэ хуулийн 46.8-д заасан журмын баримтална гэж заасны дагуу Шүүхийн

сахилгын хорооны 2024 оны төсвийн төслийг боловсруулан хүргэж байна. Хүлээн авч, хянаж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Би одоо Шүүхийн сахилгын хороо. Асуулт асууж гишүүд дууслаа.

Шүүхийн сахилгын хорооны 2024 оны төсвийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Би энэ саналын томъёолол уншиж сонсгоё.

Шүүхийн сахилгын хорооны 2024 оны төсвийн төслийг төсвийн хязгаарт нийцүүлж хасах нь зүйтэй гэдэг зарчмаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал 100 хувь дэмжигдсэнгүй.

Шүүхийн сахилгын хорооны 2024 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа.

Түрүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн хэлэлцэнтэй холбоотой Сандаг-Очир гишүүнээс санал гарсан. Бид Байнгын хороон дээрээ яриад Архангай аймгийн шүүхийн барилгыг 6.3 тэрбум төгрөгийг хасах санал дэмжигдсэнтэй холбоотойгоор төсөвт өртөг нэмэгдэхгүй байгаа. Сандаг-Очир гишүүн Багануур дүүргийн шүүхийн барилгыг санхүүжүүлэх асуудлыг тусгасан. Тийм учраас Сандаг-Очир гишүүний гаргасан санал Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн төсвийнхөө багцад бол багтаж байгаа юм.

Тийм учраас энэ зарчмаар нь багтаж байгаа учраас Сандаг-Очир гишүүний бас гаргасан саналыг тусгаад Сангийн яаманд хүргүүлж гэсэн ийм зүйлийг бас протоколд тэмдэглүүлж байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны төсвийн төслийг хэлэлцье.

Хуралдаанд Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Адъяахишиг Хүний эрхийн Үндэсний Комиссын тамгын газрын дарга, Бадамсэрээжид Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах нягтлан бодогч нар оролцож байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Хунан даргад танилцуулна. 2 номерын микрофон.

Ж.Хунан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Эрхэм хүндэт Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Хүний эрхийн Үндсэн Комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга жилийн төслийн төсвийг төлөвлөн Улсын Их Хуралд өргөн, хуралд хүргүүлэх бөгөөд төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ. Комиссын дарга Байнгын хороогоор зөвшөөрсөн төсвийн төслийг улсын нэгдсэн төсвийн төсөлд нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлнэ гэж заасныг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны төсвийн төслийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейгаас 1993 онд баталсан хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх Парисын зарчимд нийцүүлэн боловсруулж 2023 оны 6 дугаар сарын 9-ний өдөр Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн.

Комисс нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан чиг үүргээс гадна Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Хүүхдийн эрхийн

тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д Комисс үйл ажиллагаа явуулах байртай байна гэж заасан бөгөөд Комисс үүсгэн байгуулагдсанаасаа хойш 22 жилийн хугацаанд өөрийн байргүй үйл ажиллагаагаа явуулж байна.

Өнгөрсөн онд Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Эдийн засаг, хөгжлийн яам Засгийн газрын 11 дүгээр байранд нүүхтэй холбоотойгоор Хүний эрхийн Үндэсний Комисс Засгийн газрын 11 дүгээр байрнаас Засгийн газрын 12 дугаар байр руу нүүж шилжсэн.

Монгол Улсын Засгийн газрын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 5.5.1-д хүний эрхийг хангасан хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж үр нөлөө дээшилнэ. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.5.2-т төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоог төлөвшүүлнэ. “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн 4.2.1.4-д Хүний эрхийн үндэсний комиссыг Парисын зарчимд бүрэн нийцсэн хүний эрхийн үндэсний байгууллага болгож бэхжүүлнэ гэсэн заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газраас Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ой, хүний эрхийн үндэсний байгууллагуудын Парисын зарчмын 30 жилийн ой, Монгол Улсад хүний эрхийн үндэсний хөтөлбөр батлагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын байр болон Ази-Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн сургалт судалгааны төв барих зориулалтаар 1 тэрбум 507 сая төгрөгийн өртөг бүхий 2645 м² газар

эзэмших эрхийг Комисст шилжүүлэн олгосон.

Монгол Улсын Их Хурлын дарга Занданшатар парламент болон хүний эрхийн үндэсний байгууллагууд хоорондын харилцааны тухай Белградын зарчмууд хэлэлцүүлэгт хэлсэн үгэндээ энэ удаагийн Улсын Их Хурал хүний эрхийг дээдэлсэн парламент байх болно гэж онцлон тэмдэглэсэн бөгөөд сүүлийн жилүүдэд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр гаргасан Монгол Улсын хүчин чармайлт, ололт амжилтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дэд комиссар, ноён Волкер Турк Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн хуралдаанд оролцох үеэрээ өндрөөр үнэлсэн байдаг.

Дээрх үйл явдал эдийн засгийн нөхцөл байдал, үнийн өсөлттэй уялдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийг 15 тэрбум 95 сая 20219 төгрөг 35 мөнгө төгрөг байхаар төлөвлөн танилцуулж байна.

Үүнээс Комисс хуулиар олгосон хүний эрхийг хангах, хамгаалах, хөхүүлэн дэмжих чиг үүргээ хараат бусаар тасралтгүй, үр нөлөөтэй бүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах урсгал зардал 7 тэрбум 95 сая 20219 төгрөг байхаар, Хүний эрхийн Үндэсний Комиссын байр болон Ази-Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн сургалт, судалгааны төв байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын зардалд 7 тэрбум 840 сая төгрөг, ТЭЗҮ боловсруулахад 160 сая төгрөг, нийт 8 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Эрхэм хүндэт Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Хүний эрхийн чиглэлээр гаргасан ололт амжилтаа бататгах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хөхүүлэн дэмжих, хүний эрхийн соёлыг түгээх хуулиар хүлээсэн чиг үүргээ илүү хүртээмжтэй, үр дүнтэй болгоход

шаардагдах Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны төсвийн төслийг хэлэлцэн зөвшөөрч өгөхийг хүсье.

Баярлалаа.

Б.Энхбаяр: Баярлалаа. Хүний эрхийн Комиссын 2024 оны төсвийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газраас хийсэн дүн шинжилгээг гишүүдэд тараасан байгаа.

Танилцуулгатай холбоотойгоор асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Цогтбаатар гишүүнээр тасаллаа.

Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн чиглэлээр Хүний эрхийн Комиссын зүгээс хийж байгаа ажлуудыг дэмжиж байгаа. Гэхдээ энэ төртэй ажиллахдаа дуулгавартай биш, харин зөрж шаардлагууд бас тавьж ажиллаж байх ёстой. Энэ зоригийг л та нар олж аваарай гэдгийг би яриад байгаа.

Яг энэ өнцгөөсөө аваад үзэхлээр энэ юу Хүний эрхийн Комиссын бас хараат бус байдлыг хангаж өгнө гэдэг чинь зүгээр эндээс ингээд л Их Хурлын гишүүд загнаад л хараат бус бай, дарга нараас анги хараат бус бай гэж яриад байхдаа биш эрх зүйн орчныг нь, материаллаг техникийнх нь баазыг үнэхээр бас хангаж өгч байж энэ чинь өөрөө объектив шинж чанартайгаар бүрддэг. Жишээлбэл, би одоо санаж байна эднийхийг ярьж байхад нь машин авна гээд л тэгж байхад нь засгийн баазаас ав, засгийн баазаас хөдөө явах гээд машинаа авч байгаа байгууллага бол тэгээд шууд төрийн, засгийн хамааралд л байх байхгүй юу машин гуйж байгаа айл чинь.

Тэгэхлээр тэр хамааралгүй байдлыг нь үнэхээр бүрдүүлж өгөх ёстой. Тэр дотроо тэгэхлээр энэ байшин савны

асуудлыг ч гэсэн бид нар тусгах ёстой. Ер нь 12 онд л би Монголд Ази-Номхон далайн Хүний эрхийн төвийг байгуулах ёстой, дотроосоо гэрэлтдэг тийм тунгалаг ордон байх ёстой гэдэг асуудлыг ярьж байсан. Тэр үед үнэхээр ойлгож байсан хүмүүс цөөхөн. Өнөөдөр бол хүний эрхийн асуудал бол бүгдээрээ ярьдаг болчихжээ. Жаахан миний эмзэглэж байгаа зүйл бол зарим нь зүгээр моод болгож ярьдаг. Ярихад нөгөө хүмүүст таалагдаад байна гэж бодоод улс төр хийж яриад байгаа. Энэ чинь огт улс төрийн асуудал биш. Энэ цэвэр эрх зүйн асуудал.

Тийм учраас энэ дээр бид нар ул суурьтай хандаж байх ёстой. Ул суурьтай хандана гэж юуг хэлээд байгаа гэхлээр эд нарын тэр хараат бус байдлын суурийг нь баталгаажуулж өгөх ёстой. Миний асуух гэж байгаа асуулт энэ хүний эрхийн тэгэхлээр тэр бүсийн төв байгуулах барилгын асуудал орж ирж байгаа юм байна. Зөв байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын эндэх суурин төлөөлөгчтэй би ярьж байхдаа бас яг манайхыг энэ дээр нь дэмжиж өгөөч, НҮБ-аас бас дэмжиж өгөөч гээд ярьж байсан юм. Бид нар дэмжиж болно гэдэг саналыг бүүр хамт яриад сууж байсан.

Тэгэхлээр энэ төсөв чинь тэр барилгыг бүхэлд нь хамарчхаад байна уу, эс үгүй бол тодорхой хэмжээний зардлыг нь гаргаад үлдсэнийг нь гаднын бас санхүүжилт босгох тийм боломж байгаад байна уу? Энэ дээр хариулт өгөөч.

Б.Энхбаяр: Хунан дарга хариулъя. 2 номерын микрофон.

Ж.Хунан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ 8 тэрбум төгрөг бол барилга байгууламжийн зардлыг бүхэлд нь хамарч байгаа гэсэн үг. Юу гэнээ.

Б.Энхбаяр: Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв өнгөрсөн

оньхоос өнгөрсөн оньхоос чинь 10 хэд билээ, 10.1 билүү. Айн 10 тэрбум төгрөгөөр нэмэгдэж орж ирсэн байгаа юм. Энэний гол зардал нь сая хэлсэнчлэн 8 тэрбум нь байр барихаар зардал байгаа. Төсвийн хуульд зааснаар зураг төсөвгүй барилгыг төсөвт суулгахгүй гэж байгаа юм. Энэ зураг төсөв нь хийгдэж дуусаагүй байна гэж бид ойлгосон. ТЭЗҮ байхгүй байгаа. Тэгэхээр би гишүүдэд ийм зарчмаар санал хураах, ярих гээд байгаа юм. Одоо 6 сар төсвийн төсөл чинь 9 сард Засгийн газар дээр боогдоно. Бид бол зураг төсөвгүй барилгыг суулгая гэж санал хураахгүй. Хуулиараа угаасаа зураг төсөв байж байж л төсөвт суулгах учиртай.

Тэгэхээр зарчим нь Байнгын хороо бол ингээд 24 оны төсвийн төсөв Засгийн газар дээр боогдож орж ирэхээс өмнө та хэд тэр зураг төсөв юмнуудаа хийе даа, дуусаад, тэгээд Засгийн газар өөрөө дэмжээд, төсвийн төсөл боогдож орж ирэхээс өмнө зураг төсөв чинь хийгдээд Засгийн газар боовол энийг 24 оны төсөв дээр Байнгын хороо угаасаа төсвийн төсөл Засгийн газраар ороод ирвэл ярихад бол асуудал байхгүй. Санал хурааж болохгүй байгаад байгаа юм. Зураг төсөв байхгүй. Тэгэхээр чинь зураг төсөвгүй юмыг бид тоо шууд санал хурааж болохгүй байгаа байхгүй юу. Тэдэн төгрөг гээд энэ чинь төсөв зураг нь гараагүй байхад чинь. Ямар өртөгтэй байх нь гарагдаагүй, шийдэгдээгүй барилга дээр бид тодорхой тоон дүнгээр ийм санал хураах боломжгүй байгаа юм.

Тийм учраас энэ саналыг нь би дэмжих боломжгүй. Тэгэхдээ дэмжихгүй гэдэг нь зураг, төсөв нь хийгдээд, Засгийн газар ингээд оруулаад ирэхэд бол энэ асуудал нээлттэй шүү гэдэг ерөнхий нэг зарчим Байнгын хороон дээр яриад мэдээж тодорхой бас санал хурааж байж л нөгөө юу яах учраас би Хүний эрхийн Үндэсний Комиссын барилга 8 тэрбум гэснийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

Санал дэмжигдсэнгүй, 10 хувийн саналаар санал авсан байна.

Санал дэмжигдсэнгүй ээ. Тийм учраас 8 тэрбумыг хасаж хянахаар болсон шүү.

Тэгэхдээ саяын хэлсэн зарчмаар 9 сард 24 оны төсөл боогдохоос өмнө та Хүний эрхийн Комисс барилгынхаа зураг, төсвийг, ТЭЗҮ, зураг төсөл гараад тэгээд Засгийн газар өөрөө дэмжээд оруулж ирвэл энэ асуудал ярихад нээлттэй гэдгийг протоколд тэмдэглүүлж байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын орон тоог 2023 онд 82 байсныг 93 болгож 11-ээр нэмэгдүүлж гэдэг санал оруулж ирсэн байгаа. Энийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

20 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

82 ажилтны хоолны үнийн хөнгөлөлт 2023 оны 3 сарын 31-нд 19 мянга болгож нэмсэн. 24 оноос 24 мянган төгрөг болгохоор тооцсон. Хоолны үнийн хөнгөлөлтөд 104 сая, Нийгмийн даатгалын шимтгэлд 13 сая ч төгрөг нэмэхээр оруулж ирсэн байгаа. Энэ 82 ажилтны хоолны үнийн хөнгөлөлтийг үнийн хөнгөлөлтөд 104.3 сая төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 13 сая төгрөг нэмье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

30 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

82 ажилтанд улирал бүр 40 хувийн урамшуулал олгохоор тооцож оруулж ирсэн байгаа юм. Энэ бусад аль ч байгууллагад ийм юм байхгүй. Жилийн эцэст л урамшуулал тооцдог. Бүх төрийн байгууллагууд.

Хүний эрхийн Комисс бол улирал тутам 40 хувийн урамшуулал олгоно. Энд нэмэлтээр 222.9 сая төгрөг нэмэхээр оруулж ирсэн. Энэ урамшууллынх нь

зардалд тооцогдох Нийгмийн даатгалын шимтгэлд 27.8 сая төгрөг нэмэхээр оруулж ирсэн. Энийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

10 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2023 онд 7 автомашин дуудлагаар ашиглаж байгааг 2024 онд 8 автомашин ашиглахаар тооцож шатахуун дээр 57.5 сая төгрөг нэмэхээр санал оруулж ирсэн. Энийг чинь дэмжсэнгүй шүү дээ сая. Нэмэхээр оруулж ирсэн. Энэ 50, саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

30 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

50.8 сая төгрөгөөр ном, өмнөх оныхоос би дандаа нэмж байгаа дүнг нь хэлээд байгаа шүү. Энэ дэмжигдээгүй тохиолдолд 23 оноороо л батлагдаж байгаа юм. Төсвийнхөө бүүр хасагдаж байгаа гэсэн үг биш. Би зөвхөн нэмж байгаа дүнг хэлж байгаа шүү. 23 оныхоос 24 онд нэмж орж ирж байгаа дүнг хэлээд байгаа шүү.

Мэдээлэл, сурталчилгааны материал, эвхмэл хуудас, ном хэвлүүлэхэд 2024 онд 50.8 сая төгрөгөөр нэмэхээр оруулж ирсэн. Энэ саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Би хэлнэ.

20 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Гадаад албан томилолтоор 35.1 сая төгрөг өнгөрсөн оныхоос нэмэхээр тооцсон. Энэ инфляц болон энэ бол Хүний эрхийн Комисс нөгөө Хүний эрхийн тайлан, илтгэл хамгаалахтай холбоотойгоор бас гадаад улсад оролцох ийм шаардлага бас байгаа. Энийг өнгөрсөн оныхоор нь хасаж баталъя гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

10 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Тийм учраас гадаад албан томилолт дээр 35.8 сая, 35.1 сая төгрөгийг нь нэмэхээр дэмжиж байна. Дэмжигдэж байна.

Дотоод албан томилолт дээр 44.7 сая төгрөг нэмэгдүүлэхээр санал болгосон. Энийг өнгөрсөн оных нь, 23 оных нь түвшинд дотоод томилолтынх нь зардлыг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

10 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дотоод томилолт, томилолт нь 34.7 сая төгрөгөөр нь өнгөрсөн оныхоос нэмэгдүүлж баталж байна.

11.Судалгааны ажилд нийт 440 сая төгрөгөөр 11 судалгаа хийнэ гэж оруулж ирсэн. Энэ бол угаасаа төсвийн хэмнэлтийн хуулиар чинь. Энийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

30 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Хүний Монгол Улс дахь Хүний эрх чөлөөний байдлын талаарх тайлан, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайлан болон Хүний эрхийн хороодоос гаргасан ерөнхий зөвлөмжөөс хэсэгчлэн 1200 хуудас материалыг орчуулж бас Нэгдсэн Үндэстийн Байгууллагад хүргүүлэх ийм асуудал байгаа юм байна. Энэ орчуулгын зардалтай холбоотой 72 сая төгрөгийг нэмье гэсэн ийм санал оруулсан юм байна. Энийг нь нэмэхгүйгээр өнгөрсөн оных нь түвшинд нь баталъя гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

20 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. 72 сая төгрөгийг нь тэгэхээр нэмэхээр болж баталлаа.

Хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр 21 аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлэх нөлөөллийн

ажилд 31.5 сая төгрөг баталъя гэдгээр санал хураалт явуулъя.

30 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Мэдээлэл сурталчилгааны зардал. Энэ чинь угаасаа төсвийн хэмнэлтийн хуулиар байхгүй болчихсон байсан. Тэх.

Мэдээлэл сурталчилгааны зардалд 308.5 сая төгрөгийг тусгая гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

30 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 126 сая төгрөгөөр нэмэгдүүлье гэдэг санал ирүүлсэн. Энэ саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

30 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Хорин нэгэн аймгийн ажилтанд сар бүр 20 хувийн цалинтай тэнцэх дэмжлэг үзүүлэхэд 93 сая төгрөг баталъя гэдэг санал ирүүлсэн байна. Энэ саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

30 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Албан хаагчдад нэг удаагийн тусламж, дэмжлэг олгоход 56.5 сая төгрөгөөр нэмэгдүүлье гэж байгаа юм уу. Нэмэгдүүлэх санал ирүүлсэн байна. 2023 онд энэ зардал 40.1 сая төгрөг байсан юм байна. Энийгээ хэд больё гэж байна. 96.5 болгон, 96.5 сая төгрөг болгоё гэсэн ийм санал гаргасан юм байна. Хэдэн хувиар нэмэгдүүлж байгаа юм 45 хувь юм уу. Биш ээ энэ чинь өөр. 2 аравны хэд нэмэгдэж байгаа юм байна шүү дээ.

56.5 сая төгрөгөөр нэмэгдүүлье гэдэг үгээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

30 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Санал хурааж дууслаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын 2024 оны төсвийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудал.

14.26 цаг

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Нийтийн сонсголын тухай хуулийн 20.3.2-т ерөнхий хяналтын төсвийн болон томилгооны сонсголыг тухайн хүсэлтийг эрх бүхий байгууллага хэлэлцэн, товлосноос хойш 7 хоногийн дотор нийтэд зарлана гэж заасан. Улсын Их Хурлын тухай хуулийн 25.6-д бодлогын баримт бичиг боловсруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газар холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх шаардлагатай бол Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд тогтоол гаргаж болно гэж заасан. Энэтэй холбоотойгоор Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төслийг уншиж сонсгоё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1 дэх хэсэг, 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Н.Батзоригтой хийх нэр дэвшигчийн сонголыг 2023 оны 10 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонгогч даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Бат-Амгаланг томилсугай.

3. Нэр дэвшигч хандан асуух асуулт, саналыг 2023 оны 7 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

4. Нэр дэвшигчийн сонголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг хангаж холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Б.Энхбаярт даалгасугай гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Санал хураалтын томъёоллыг та бүхэнд уншиж сонсгоё.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонгогч даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцъё. Энэ сая тоног төхөөрөмж яг санал хурааж байхад бүүр ажилласангүй.

Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

14.35 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР